



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 он 08 сар 28 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Захиргааны зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2025 оны 05 дугаар сарын 22 өдрийн А/56 тоот тушаалаар баталсан “ОУУБИС-д Профессор багш ажиллуулах, үнэлэх журам”-ыг шинэчлэн баталж доорх өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Журмын 10.2.1.5, 10.2.1.6, 10.2.1.7, 10.2.1.8 дах заалтуудыг хассугай.
 - 1.2. Журамд 10.2.1.5, 10.2.1.6, 10.2.1.7, 10.2.1.8, 10.2.1.9 дэх заалтуудыг нэмсүгэй.
 - 1.3. Журмын 2.5.1, 10.2.1.4, 10.2.3.1 дэх заалтын 1, 10.2.3.4, 10.2.4.1 дэх заалтын “Сургалтын материал, ном, хэвлэл”, “Үзэсгэлэнд тавигдсан бүтээл (Мэргэжлийн салбарын болон улсын хэмжээнд), “Оновчтой санал (зохиогчийн эрх авсан)”, “Хянан тохиолдуулсан бүтээл”, “Сургалтын кино”, 10.2.4.2 дахь заалтын 1, 10.2.4.2 дахь заалтын 5-д заасныг тус тус нэмж өөрчлөн найруулсугай.
2. Тус журмын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/56 тоот тушаалаар баталсан “ОУУБИС-д Профессор багш ажиллуулах, үнэлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Журмыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалтын алба (Б.Туяа), Эрдэм шинжилгээ, багшийн хөгжлийн алба (О.Амарсанаа)-д тус тус үүрэг болгосугай.

РЕКТОР



КАН ЮУ ЁЛЬ



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬД ПРОФЕССОР БАГШ АЖИЛЛУУЛАХ, ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн багшид тавигдах шаардлага, эрх үүрэг, багш авах, ажиллуулах, ажилласан жил, орон тоо, албан тушаалын зэрэглэл тогтоох, багшийн сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч үйл ажиллагаа, багшийн ажлыг үнэлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэ журмаар зохицуулаагүй асуудлыг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ОУУБИС-ийн дүрэм, Багшийн ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

Хоёр. ОУУБИС-ийн багшид тавигдах шаардлага

2.1. ОУУБИС-ийн профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш зэрэглэлтэй багшийг “Олон Улсын Улаанбаатарын Их Сургуулийн багш” /цаашид багш гэнэ/ гэх бөгөөд багш нь энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

2.2. Багшийн гүйцэтгэж буй сургалт, судалгааны ажлын чанар, үр дүнг харгалзан ОУУБИС-ийн багш нарыг профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн албан тушаалын 5 зэрэглэлд ажиллуулна.

2.3. Албан тушаалын тодорхой зэрэглэлд ажиллаж байгаа багш нь ОУУБИС-ийн бусад журмаар тогтоосон хэмжээний сургалт, эрдэм шинжилгээ болон нийгмийн үйлчилгээний ажлыг гүйцэтгэнэ.

2.4. ОУУБИС-ийн бакалаврын түвшинд хичээл заах багш нь магистр болон түүнээс дээш, ахисан түвшний сургалтад хичээл заах багш докторын зэрэгтэй байна.

2.5. ОУУБИС-ийн багш нь Боловсрол судлал, сэтгэл судлалын арга зүйг эзэмшсэн, багшлах эрхтэй, гадаад хэлний өндөр түвшний мэдлэг чадвартай байна.

2.5.1. Багш, гадаад хэлний боловсрол (англи хэл), Гадаад хэлний орчуулга (англи хэл) хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар англи хэлний түвшин тогтоох шалгалтын IELTS 8-9, TOEFL IBT 108-120 оноо авсан байх, Багш, гадаад хэлний боловсрол (солонгос хэл), Гадаад хэлний орчуулга (солонгос хэл), Олон улс, орон судлал (солонгос судлал)-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (ТОPIK)-ын 6 дугаар түвшинд тэнцсэн байна. Шалгалтын оноо нь тухайн шалгалтын хүчинтэй хугацаанд хүчин төгөлдөр байна. Доктор зэрэгтэй багш нар үүнд хамаарахгүй.

2.6. Багш нийт сургалтын цагийн 60 доошгүй хувийг үндсэн хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэших хичээлээр гүйцэтгэсэн бол тухайн хөтөлбөрийн багш гэж үзнэ.

2.7. Багш 1 улиралд 3-аас, жилд 6-аас илүүгүй хичээл дэд бакалавр, бакалаврын болон ахисан түвшинд зааж болно.

2.8. Хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэших хичээлийн 20 хүртэл хувийг шаардлага хангасан гэрээт багшаар заалгаж болно.

2.9. Үндсэн мэргэжлийн хичээл заадаг багш ОУУБИС-д ажилласнаас хойш 10 жилийн дотор докторын зэрэг хамгаалах шаардлагатай. Тэнхимд тухайн мэргэжлийн багш хүрэлцээгүй, заалгах цаг хүрэлцээтэй байгаа тохиолдолд тэдгээр багшийг холбогдох, тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн зөвхөн сургалтын цаг биелүүлэх

нөхцөлөөр ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд эрдэм шинжилгээний багц цагийг сургалтын багц цагаар шилжүүлэн гүйцэтгүүлнэ.

2.10. ОУУБИС-ийн багш нь холбогдох тушаал шийдвэр, дүрэм журам, стандартыг мөрддөг, хэрэгжүүлдэг, бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч чанар эзэмшсэн байна.

2.11. Сургалтын үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой төлөвлөдөг, үр ашигтай зохион байгуулж манлайлан удирддаг, үр дүнг оновчтой тодорхойлох арга барил эзэмшсэн байна.

2.12. Судалгааны ажлын арга зүйд суралцсан, онолын болон практик судалгааны ажлыг цогцоор явуулах арга барилд суралцсан байна.

2.13. Багш өөрөө тасралтгүй суралцаж, мэргэжлийн мэдлэг, чадвараа байнга дээшлүүлдэг, сургалтад мэдээллийн технологи ашиглах чадвартай байна.

2.14. Багшийн аттестатчиллын үнэлгээнд хангалтгүй дүн үзүүлж, эрдэм шинжилгээ, сургалт заах аргын ур чадварын хувьд өсөөгүй, цаашид багшаар ажиллуулах боломжгүй болсон, мөн багшийн ёс зүйн зөрчил гаргасан багштай хөдөлмөрийн хууль болон бусад холбогдох журмын дагуу хариуцлага тооцно.

2.15. Багшийн тэтгэвэр тогтоолгох насны хязгаар Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар байна. Тэтгэвэр тогтоох насанд хүрсэн багшийн хөдөлмөрийн гэрээг тухайн хичээлийн жилийн эцэст дуусгавар болгож гэрээг цуцална. Тухайн багшийн мэргэжил, ур чадварыг үндэслэн бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимийн саналаар докторын зэрэгтэй багшийг 30%, 50% ачааллаар зөвлөх профессороор ажиллуулж болно. Ректор, Бүрэлдэхүүн сургуулийн захирал, Сургалтын алба, мэргэжлийн тэнхим зөвшилцсөний үндсэн дээр онцгой шаардлагатай ажлын байранд эрдмийн зэрэг цолтой багшийг 70%, 100% ачааллаар ажиллуулж болно.

75-аас дээш насны багштай хөдөлмөрийн гэрээг байгуулахгүй байж болно.

Гурав. Багшийн эрх

3.1. Багш нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, сургуулийн дүрэм болон бусад эрх зүйн актуудад заасан эрх, үүргийг хүлээж ажиллана.

3.2. Судалгаа шинжилгээ, ажлын үр дүнг нээлттэй, чөлөөтэй тайлагнах, эрдмийн эрх чөлөөтэй байх;

3.3. Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудалд үнэлгээ дүгнэлт өгөх, санал шүүмжлэл гаргах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

3.4. Мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдах, холбогдох журамд заасан хөнгөлөлт эдлэх, тэтгэлэг, дэмжлэг авах;

3.5. Бүтээлийн чөлөө авах, бүтээлээ үнэлүүлэх, шагнал урамшуулал авах;

3.6. Хичээлийн жил бүр хийсэн ажлаа дүгнүүлэн хууль ёсны амралт эдлэх;

Дөрөв. Багшийн үүрэг

4.1. ОУУБИС-ийн дүрэм журмыг мөрдөх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, биелэлтийг цаг хугацаанд нь дүгнүүлж байх;

4.2. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, суралцагчийн бие даан суралцах хэрэглэгдэхүүн, ном, сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлэх, суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх сорилго боловсруулах, цахим сургалтын контент бэлтгэх, багшийн журналыг хөтлөх;

4.3. Мэдлэг, чадвар, заах арга барилаа байнга дээшлүүлж, сургалтын технологийн шинэчлэлд хувь нэмэр оруулж байх;

4.4. Хичээлийн агуулгыг нийгмийн болон салбар шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчилж байх;

- 4.5. Хичээлийн цагийг үр өгөөжтэй ашиглах, суралцагчидтай ажиллах, зөвлөгөө өгөх хуваарийг баримтлах, даалгаврыг цаг тухайд нь шалгаж, суралцагчдад бие даан ажиллах чадвар эзэмшүүлэх;
- 4.6. Суралцагчдын мэдлэг, чадварыг шалгах хэлбэр, шалгалтын агуулгын хүрээ, үнэлэх шалгуурыг нь тодорхой байлгах, үнэлж дүгнэхдээ тэгш шударга бодитой хандах;
- 4.7. Хичээл таслах, хоцрох, эрт тараах, хичээлийн цагаар танхимыг орхиж гарах зэргээр сургалтын хэвийн ажиллагааг алдагдуулахгүй байх;
- 4.8. Сургалтын талаар тавигдаж байгаа бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцох;
- 4.9. Эрдэм шинжилгээ, сургалтын болон бусад ажлаа тайлагнаж, холбогдох хугацаанд үнэлүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар санаачилгатай ажиллаж, өөрийн мэргэжлийн салбарт гарсан шинжлэх ухааны шинэ нээлт, ололт амжилттай танилцаж зааж буй хичээлдээ тусгадаг байх;

Тав. Багшийн ёс зүй

- 5.1. ОУУБИС-ийн багшийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох эрх зүйн хэм хэмжээг баримтлан хариуцлага хүлээлгэнэ.
- 5.2. Мэргэжлээрээ тэргүүлэгч байж, ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэх, хамт олон, оюутанд чин сэтгэлээр хандаж, шударга бус явдалтай эвлэршгүй байхыг чухалчилна.
- 5.3. Мэргэжлийн мэдлэг ур чадвараа эрхэмлэх, эрдэм оюуныг бусад эрх ашгаас ямагт дээгүүр тавина.
- 5.4. Хувийн болон хүмүүс хоорондын зохисгүй сөрөг харьцаанаас ангид ажиллаж, алба амины харилцааг зааглах, бусдыг хилсээр буруутгах, мэдээллийг гуйвуулахаас зайлсхийх;
- 5.5. Суралцагчдын асуулт, тавьсан саналыг анхааралтай сонсож, үнэн зөв, хариултыг хамтран ярилцаж тэдний сэтгэлд нийцсэн дүгнэлт гарган зөвлөж байх;
- 5.6. Суралцагчдын алдаа мадагтай асуулт, хариултад дургүйцэж хэл амаар доромжлох, мушгин гуйвуулах, заналхийлэх зэргээр ёс суртахууны доголдол гаргахгүй байх;
- 5.7. Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн суралцагчийн хөдөлмөрийг ашиглах, суралцагчийг хүйсээр болон бусад байдлаар ялгаварлах зэргээр багшийнхаа давуу талыг ашиглан суралцагчдад дарамт шахалт үзүүлэхгүй байх;

Зургаа. ОУУБИС-д багш шинээр авах

- 6.1. Энэхүү журмын 2 дугаар бүлэгт заасан ОУУБИС-ийн багшид тавигдах шаардлагыг хангасан иргэнийг үндсэн багшаар авч ажиллуулна.
- 6.2. Багшийн сонгон шалгаруулалтыг хичээлийн жилд 1-2 удаа улирал эхлэхээс өмнө зохион байгуулна. ОУУБИС-д багшийг дараах 2 хэлбэрээр авч ажиллуулна. Үүнд:
 - 6.2.1. Багшид тавигдах шаардлага хангасан хүнийг сонгон шалгаруулалтаар авах,
 - 6.2.2. Өндөр мэргэшлийн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр авч ажиллуулах,
- 6.3. Багшийг сонгон шалгаруулалтаар авахад дараах зарчмыг баримтална. Үүнд: Багшийн сонгон шалгаруулалтын зарыг Захиргаа хүний нөөцийн алба зохион байгуулах ба сургуулийн цахим хуудсаар олон нийтэд нээлттэй хүргэнэ. Шалгаруулалтыг хүний нөөцийн зөвлөл мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуультай хамтран зохион байгуулна.
- 6.4. Сонгон шалгаруулалтад оролцогчид ажил байдлын тодорхойлолт, төрийн албан хаагчийн анкет, боловсролын диплом болон иргэний үнэмлэхийн хуулбар, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвар, хувь хүний төлөв байдал, мэргэжлийн ёс зүй зэргийг тодорхойлсон ажил байдлын

тодорхойлолт, сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлгийн магадалгаа зэрэг шаардлагатай материалыг бүрдүүлнэ.

6.5. Сонгон шалгаруулалтад орох болзол хангаж, бүртгүүлсэн иргэдээс хүний нөөцийн зөвлөл болон мэргэжлийн тэнхимийн эрхлэгч оролцсон 3-5 хүний бүрэлдэхүүнтэй комисс ректорын тушаалаар томилогдож шалгалт /амаар эсхүл бичгээр/, ярилцлага зохион байгуулж, эрдэм шинжилгээний бүтээлд нь үнэлгээ өгнө.

6.6. Мэргэжлийн шалгалтад тэнцсэн иргэдээс англи хэлний шалгалт авах бөгөөд шалгалтад 70 болон түүнээс дээш оноо авсан бол тэнцсэнд тооцно. Олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэгддэг түвшин тогтоох шалгалтын /TOFEL, IELTS/ оноотой бол шууд тооцуулж болно.

6.7. Сонгон шалгаруулалтад тэнцэж багшаар ажиллах болзол хангасан нэр дэвшигчийг ОУУБИС-ийн ректорын тушаалаар ажилд томилно.

6.8. Сонгон шалгаруулалтаар шинээр авсан багшийг дадлагажигч багшийн зэрэглэлд авсан бол 1 хичээлийн жил ажиллуулсны дараа бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн цаашид ажиллуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.9. Эрдэм шинжилгээний бүтээлээрээ тухайн салбартаа олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн эрдэмтнийг /профессор эсхүл дэд профессор цолны шаардагдах оноог бүрэн хангасан/ сонгон шалгаруулалтгүйгээр дэд профессор, профессорын зэрэглэлд ажиллуулж болох бөгөөд бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимийн саналын дагуу хүний нөөцийн зөвлөл шийдвэрлэнэ.

6.10. Өндөр мэргэшлийн эрдэмтнийг урьж ажиллуулахдаа шинээр авч байгаа багштай адил хичээлийн жилийн нэг улирлын хугацаанд туршилтаар ажиллуулсны дараа бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн цаашид ажиллуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Долоо. Албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага

Харгалзах зэрэглэлд дэвшин ажиллах багш нь уг журмын үндсэн болон тусгай шаардлагуудыг бүрэн хангасан байна.

7.1. Дадлагажигч багшийн зэрэглэлд тавигдах шаардлага:

Үндсэн шаардлага:

7.1.1. Мэргэжлээрээ багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх;

7.1.2. Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хийж гүйцэтгэх хүсэл сонирхолтой, тодорхой чиглэлээр судалгаа хийсэн бэлтгэлтэй, багшийн ёс зүйн шаардлагыг хангасан байх;

7.1.3. Судалгаа эрдэм шинжилгээний итгэл, өгүүлэл бичих, хэвлүүлэхэд суралцах;

7.1.4. Удирдлагын зөвлөгөөний дагуу танхимын болон зайн сургалтын хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах чадвар эзэмшсэн байх;

7.1.5. Заах арга зүйн болон мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэх, холбогдох сургалт, дадлагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх;

7.1.6. Суралцагч болон олон нийтэд чиглэсэн мэргэжлийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох;

7.1.7. Дадлагажигч багшийн зэрэглэлд ажиллах багштай 1 жилийн гэрээ байгуулна.

Тусгай шаардлага:

7.1.8. Заадаг хичээлүүдийн агуулга, арга зүйг сайжруулан бүрэн эзэмших;

7.1.9. Ахмад багш нарын туршлагаас суралцах, эрдэм шинжилгээний ажлын сэдвээ тогтох, судалгааны ажлын арга барил эзэмших;

7.1.10. Багш мэргэжлийн биш дадлагажигч багш их дээд сургуульд багшлах эрх авах;

7.2. Багшийн зэрэглэлд тавигдах шаардлага

Үндсэн шаардлага:

- 7.2.1. Дээд боловсролын байгууллагад, эсвэл ОУУБИС-ийн дадлагажигч багшийн зэрэглэлд 1-ээс дээш жил ажилласан, магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- 7.2.2. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, үндсэн мэргэжлийн дагуу эрдэм шинжилгээний байгууллагад эсвэл бусад их дээд сургуульд 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 7.2.3. Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг чанартай гүйцэтгэх чадвартай болохоо харуулсан тодорхой үр дүнтэй байх;
- 7.2.4. Бие даасан болон хамтарсан эрдэм шинжилгээний бүтээл туурвих;
- 7.2.5. Гадаад дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, судалгааны ажлын үр дүнгээ түгээн дэлгэрүүлэх;
- 7.2.6. Салбар, мэргэжлийн чиглэлийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцох;
- 7.2.7. Нийгмийн соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын мэргэжлийн үйл ажиллагаанд оролцох;
- 7.2.8. Багшид тавигдах ёс зүйн болон бусад шаардлагыг хангасан, үүрэгт ажлаа бүрэн биелүүлдэг, оюутанд мэдлэг, мэргэжлийн ур чадвар, судалгааны ажлын арга барил төлөвшүүлдэг байх;

Тусгай шаардлага:

- 7.2.9. Үндэсний болон салбар мэргэжлийн түвшинд судалгаа явуулах, туршилт хийх, дүгнэх, тайлагнах ажлыг гардан гүйцэтгэх;
- 7.2.10. Тодорхой чиглэлээр тогтмол эрдэм шинжилгээ судалгааны ажил хийдэг, түүнийгээ нийтийн хүртээл болгодог байх;
- 7.2.11. Тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрийн агуулга, уялдаа холбоог нарийвчлан сайжруулдаг, мэргэжлийн заах арга, боловсролын түвшнээ дээшлүүлэх, докторантурт суралцаж төгсөх;
- 7.2.12. Хичээлээ батлагдсан хөтөлбөрийн дагуу чанартай заадаг, хөтөлбөрийн агуулгад хийх шинэчлэлийг байнга анхаарч сургалтын үйл ажиллагааны журмыг бүрэн биелүүлдэг байх;
- 7.2.13. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байх;
- 7.2.14. Танхимын болон зайн сургалтын материал, E-контент боловсруулах чадвартай байх;
- 7.2.15. Сүүлийн 3 жил А, Б, В цагийн гүйцэтгэл 100% байх;

7.3. Ахлах багшийн зэрэглэлд тавигдах шаардлага

Үндсэн шаардлага:

- 7.3.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн доктор(Ph.D)-ын зэрэгтэй залуу эрдэмтнийг ахлах багшийн зэрэглэлд шууд ажиллуулж болно.
- 7.3.2. Дээд боловсролын байгууллагад 8-аас дээш жил, ОУУБИС-ийн багшийн зэрэглэлд 4 жил үр бүтээлтэй ажилласан магистр буюу түүнээс дээш зэрэгтэй байх.
- 7.3.3. ОУУБИС-д багшийн зэрэглэлд ажиллаж байгаад докторын (Ph.D) зэрэг хамгаалбал шууд ахлах багшаар дэвшүүлэн ажиллуулж болно.
- 7.3.4. Тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны бие даасан болон хамтын бүтээлийг тогтвортой туурвиж, олон нийтийн хүртээл болгодог байх;
- 7.3.5. Эрдэм шинжилгээний төсөлт ажилд оролцож, эрдэм шинжилгээний хурал, семинарт тогтвортой илтгэл хэлэлцүүлдэг байх;

7.3.6. Оюутанд мэдлэг, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэхээс гадна багшлах болон үйлдвэрлэлийн дадлагыг үр бүтээлтэй удирдан хийлгэж, судалгааны ажлын арга барилд сургадаг байх;

7.3.7. Багшид тавигдах ёс зүйн болон бусад шаардлагыг хангасан, үүрэгт ажлаа бүрэн биелүүлдэг, бусдад үлгэрлэдэг байх;

Тусгай шаардлага:

7.3.8. Тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрийн агуулгыг нарийвчлан сайжруулах, мэргэжлийн заах аргыг баяжуулах;

7.3.9. Мэргэжлийн хөтөлбөр болон хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, чанарын баталгаажилтын үйл ажиллагаанд илүү үүрэгтэй оролцож, залуу багш нарт зөвлөх чадвартай байх;

7.3.10. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өндөр түвшинд гүйцэтгэх, улмаар докторантурт суралцаж төгсөх;

7.3.11. Үндсэн мэргэжлийн чиглэлээр 3-аас дээш гарын авлага бичиж хэвлүүлсэн байх;

7.3.12. Батлагдсан эрдэм шинжилгээний удирдагчийн удирдлагаар тодорхой сэдвээр судалгааны ажил хийдэг байх;

7.3.13. Сүүлийн 3 жилийн дунджаар эрдэм шинжилгээний өгүүлэл 3-аас доошгүй хэвлүүлсэн байх;

7.3.14. Компьютерын программ хангамж, дизайн, урлаг, спортын мэргэжлийн хүмүүсийн бүтээсэн зураг төсөл, практикт нэвтрүүлж албан ёсоор баталгаажуулсан программ хангамж, спорт, урлагийн амжилтыг эрдэм шинжилгээний бүтээлтэй адилтган авч үзнэ.

7.3.15. Төсөл хөтөлбөрийн санхүүжилт босгох, гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, төслийн баг судлаачдыг удирдах, дэмжлэг үзүүлэх;

7.3.16. Салбар мэргэжлийн чиглэлээр дүрэм, журам, зөвлөмж, стандарт, арга зүй боловсруулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;

7.3.17. Мэргэжлийн холбоод, салбарын байгууллага мэргэжилтнүүдийг чадавхжуулах үйл ажиллагаанд оролцох;

7.3.18. Нийгмийг соён гэгээрүүлэх олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч байх;

7.2.19. Сүүлийн 3 жил А, Б, В цагийн гүйцэтгэл 100% байх;

7.4. Дэд профессорын зэрэглэлд тавигдах шаардлага

Үндсэн шаардлага

7.4.1. Доктор (Ph.D) болон түүнээс дээш зэрэгтэй, докторын зэрэг хамгаалаад ОУУБИС-д 4-өөс дээш жил үр бүтээлтэй ажилласан байх;

7.4.2. Дээд боловсролын байгууллагад 10-аас дээш жил, ОУУБИС-д ахлах багшийн зэрэглэлд 4-өөс доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, доктор зэрэгтэй байна.

7.4.3. Эрдэм шинжилгээний бүтээл туурвихын зэрэгцээ төсөлт ажил, эрдэм шинжилгээний хурал, семинар удирдах, судалгааны арга зүй, ур чадварыг өндөр түвшинд эзэмшсэн байх;

7.4.4. Боловсрол, сургалтын байгууллагын бодлогын баримт бичиг боловсруулах, сайжруулахад санал оруулах, биечлэн оролцох;

7.4.5. Мэргэжлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйг сайжруулах, дотоодод болон олон улсад магадлан итгэмжлүүлэх үйл явцад голлох үүрэг хүлээх;

7.4.6. Салбар дундын хөтөлбөр, хамтарсан хөтөлбөр боловсруулах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажилладаг байх;

7.4.7. Багшлахуй, суралцахуйн ур чадвар, туршлагаа ахлах багш, багш, дадлагажигч багш нарт заан сургаж, түгээн дэлгэрүүлдэг байх;

- 7.4.8.Магистрант, докторант оюутнуудыг дагалдуулан мэргэжлийн ур чадвар, эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургадаг байх;
- 7.4.9.Тэнхим, хамт олныг удирдан манлайлж ажилладаг байх;
- 7.4.10.Мэргэжлийн холбоод, салбарын байгууллага мэргэжилтнүүдийг чадавхжуулах үйл ажиллагаанд оролцох, хөтөлбөр арга, арга зүйг боловсруулах;

Тусгай шаардлага:

- 7.4.11.Мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, тус сургуулийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах;
- 7.4.12.Сургуулийн эрхэм зорилго, хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд манлайлан ажиллах;
- 7.4.13.Олон улсын түвшинд болон үндэсний түвшинд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх, удирдах;
- 7.4.14.Судалгааны бүтээлийг удирдах, хянан магадлах, үнэлэх үйл ажиллагаанд оролцох;
- 7.4.15.Мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг хөгжүүлэх, редакцын зөвлөл, мэргэжлийн зөвлөлд ажиллах;
- 7.4.16.Тухайн салбарын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцох;
- 7.4.17.Нийгмийн сайн сайхны төлөөх олон нийтийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг санаачлан уриалагч байх;
- 7.4.18.Магистрын сургалтад хичээл заадаг байх, 5-аас дээш магистрын ажил удирдаж хамгаалуулсан байх;
- 7.4.19.Үндсэн мэргэжлийн чиглэлээр 1-ээс дээш сурах бичиг, 3-аас дээш гарын авлага бичиж хэвлүүлсэн байх;
- 7.4.20.Сүүлийн 3 жилийн дунджаар эрдэм шинжилгээний өгүүлэл 4-өөс доошгүй, үүнээс олон улсын хэмжээний өгүүлэл 2-оос доошгүй хэвлүүлсэн, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх;
- 7.2.21.Сүүлийн 3 жил А, Б, В цагийн гүйцэтгэл 100% байх;

7.5. Профессорын зэрэглэлд ажиллуулах

- 7.5.1.Дээд боловсролын байгууллагад 15-аас дээш жил, ОУУБИС-д дэд профессорын зэрэглэлд 6 жил ажилласан, доктор зэрэгтэй, дэд профессор цолтой байна.
- 7.5.2.Мэргэжлийн салбартаа хүлээн зөвшөөрөгдөх эрдэм шинжилгээний бүтээл туурвисан, төсөл, гэрээт ажил, дотооддоо болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар удирдах ур чадвартай байх;
- 7.5.3.Эрдэм шинжилгээ, судалгааны ажлынхаа үр дүнг үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжүүлдэг байх;
- 7.5.4.Үндэсний болон улсад хэрэгжих, нийгэм болоод тухайн салбарын хөгжилд шаардлагатай төслийг санаачилж, санхүүжилт босгон хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах;
- 7.5.5.Гадаад, дотоодын хамтын ажиллагаа, стратегийн түншлэлээр дамжуулан сургалтын хөтөлбөрийг сайжруулж, салбарын хөгжлийн ирээдүйд шаардлагатай шинэ хөтөлбөрийг нээх, хэрэгжүүлэх чиглэлээр санаачилга гаргах, үйл ажиллагаанд нь удирдан чиглүүлэх үүрэгтэй оролцох;
- 7.5.6.Дадлагажигч багш, багш, ахлах багш, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багш нарыг манлайлан удирдах, зөвлөн туслах, туршлагаа хуваалцдаг байх;

Тусгай шаардлага

7.5.7. Мэргэжлийн салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг тодорхойлон гарц, шийдлийг таамаглах, тодорхойлох, шинэ санал санаачилга, үзэл баримтлал гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сургууль болон үндэсний хэмжээнд зохион байгуулах;

7.5.8. Багш нарыг шинэ мэдээллээр хангах, багш, магистр, докторантыг дагалдуулах, удирдах зэргээр мэргэжлийн болон эрдэм шинжилгээний арга барилд сургадаг байх;

7.5.9. Тухайн салбар, мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний ажлыг цогц байдлаар удирдан зохион байгуулж, нийгмийн өмнө хүлээх тус сургуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах;

7.5.10. Магистр, докторын сургалтад хичээл заадаг байх, 8-аас доошгүй магистр, докторын ажил удирдсан (хэрэв докторын ажил удирдаагүй бол 15-аас дээш магистрын ажил удирдсан) байх;

7.5.11. Үндсэн мэргэжлийн чиглэлээр 2-оос доошгүй сурах бичиг, 5-аас дээш гарын авлага бичиж хэвлүүлсэн байх, сүүлийн 3 жилийн дунджаар эрдэм шинжилгээний өгүүлэл 7-оос доошгүй хэвлүүлсэн, олон улсын эрдэм шинжилгээний хэвлэлд 3 хүртэлх бүтээл хэвлүүлсэн байх;

7.5.12. Үндэсний хэмжээнд болон олон улсын түвшинд хэрэгжсэн 5-аас доошгүй төсөлд оролцсон байх;

7.5.13. Мэргэжлийн сэтгүүлийн санаачлагч болон редактораар ажилласан байх;

7.5.14. Зохиогчийн эрхийн гэрчилгээ бүхий бүтээл туурвисан байх;

7.5.15. Сүүлийн 3 жил А, Б, В цагийн гүйцэтгэл 100% байх;

Найм. Албан тушаалын зэрэглэл ахиулах

8.1. Албан тушаалын зэрэглэлээ шинэчлэн тогтоолгох хүсэлтэй багш, зэрэглэлийн ерөнхий болон тусгай шаардлагуудыг хангасан өөрийн үнэлгээний тайланг сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний ажлын чиглэлээр бичиж, тэнхим салбараар хэлэлцүүлэн сургалтын албанд өгнө. Зэрэглэл шинэчлэн тогтоох ажлыг багш нарын асуудал хариуцсан хүний нөөцийн зөвлөлөөр хэлэлцэж жилд 1 удаа (хавар) зохион байгуулна.

8.2. Багшийн албан тушаалын зэрэглэлийн дагуу гэрээ хийж ажиллуулах ба гэрээний хугацаа дуусах бүр албан тушаалын зэрэглэлийн шаардлага хангаж байгаа эсэхийг энэ журмын 7-д заасны дагуу тогтоож ректорын тушаалаар баталгаажуулна.

8.3. Профессор, дэд профессорын зэрэглэлд дэвшүүлэх асуудлыг багшийн асуудал эрхэлсэн хүний нөөцийн зөвлөлөөр, цол олгох асуудлыг эрдмийн зөвлөлөөр тус тус хэлэлцэж шийдвэрлэнэ.

8.4. Тодорхой зэрэглэлд ажиллаж байгаа багшийн хувьд тухайн зэрэглэлд ажиллаж байгаа хугацаа, энэ хугацаанд гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзан хүний нөөцийн зөвлөлийн шийдвэрийн дагуу ректорын тушаалаар баталгаажуулна.

8.5. Албан тушаалын зэрэглэлийн үндсэн шаардлагыг хангаж байгаа багшийн ажиллаж байгаа зэрэглэлийн хугацаа дууссан боловч тодорхой шалтгааны улмаас зэрэглэл дэвших боломжгүй бол тухайн зэрэглэлд үргэлжлүүлэн ажиллуулна.

8.6. Багш нь тухайн албан тушаалын зэрэглэлд ажиллах хугацаандаа уг зэрэглэлийн шаардлагыг хангахгүй, гэрээний нөхцөлийг биелүүлээгүй, “багшийн аттестатчилал”-д хангалтгүй дүн үзүүлсэн бол анхааруулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх, зэрэглэл бууруулах, улмаар гэрээ цуцлах арга хэмжээ авна.

8.7. Багшаар ажиллуулах гэрээг цуцлахдаа багшийн асуудал эрхэлсэн хүний нөөцийн зөвлөлийн албан ёсны дүгнэлтийг үндэслэн, хөдөлмөрийн хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

Ес. ОУУБИС-ийн багшийн хичээлийн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ

9.1.ОУУБИС-д багшийн ажлыг кредит гэсэн нэгжээр хэмжих бөгөөд 48 цагийн хөдөлмөрийг 1 кредит (цаашид *кр* гэж товчилно) гэнэ.

9.2.ОУУБИС-ийн багш нь

А. Сургалт (доор А хэсэг гэнэ)

Б. Эрдэм шинжилгээ (Б хэсэг)

В. Нийгмийн үйлчилгээ (В хэсэг)

гэсэн гурван төрлийн ажил гүйцэтгэнэ.

9.3.Хичээлийн жилд багшийн гүйцэтгэх ажлын нийт хэмжээ нь 25 *кр* байх ба албан тушаалын зэрэглэлээс хамааран дараах задаргаатай байна:

Албан тушаалын зэрэглэл	Сургалт (кр)	Эрдэм шинжилгээ (кр)	Нийгмийн үйлчилгээ (кр)
Профессор	12	9	4
Дэд профессор	14	7	4
Ахлах багш	16	6	3
Багш	18	4	3
Дадлагажигч багш	15	3	7

9.4.Дадлагажигч багш нь ахмад туршлагатай багш нарын туршлагаас суралцах зорилгоор дөрвөөс доошгүй *кр*-ийн хичээлд сууж судлах ба их дээд сургуульд “багшлах эрх” олгох сургалтад сурах, тэнхимээс хуваарилсан хичээлийн агуулгыг эзэмших, заахад бэлтгэж 7 *кр* хуримтлуулна.

Арав. Сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тооцох

10.1. А. Сургалтын ажлыг тооцох

10.1.1.Бакалавр, магистр болон докторын түвшний сургалтад лекц унших, семинар, лаборатори, дадлагын (цаашид *дадлага* гэж товчилж бичнэ) хичээлийг удирдан явуулах нь сургалтын ажлын үндсэн хэлбэр болно.

10.1.2.Дээрх хэлбэрийн сургалтын 1 *кр*-ийн хөдөлмөрт хичээлд бэлтгэх, танхимд хичээл явуулах, хичээлийн агуулгаар оюутанд зөвлөгөө өгөх болон оюутны мэдлэг, чадварыг үнэлэх багц ажлыг багтаах бөгөөд хичээлийн хэлбэрээс хамаарч тэдгээрийн харьцаа хэмжээг нь тогтооно.

Кредитийн бүтэц	Танхимын сургалт	Сургалта д бэлтгэх	Суралцагчд ад зөвлөгөө өгөх	Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх	Кредит
Хичээлийн хэлбэр					
лекц	16 цаг	12 цаг	16 цаг	4 цаг	1кр
Семинар, дадлага, лаборатори	32 цаг	8 цаг	4 цаг	4 цаг	1кр

10.1.3.Багш нь сургалтын ажлынхаа зургааны нэг хувийг оюутантай ганцаарчлан ажиллахад зориулдаг байна.

10.1.4.Багшийн сургалтын ажлын цагт бакалавр, магистр, докторын дипломын ажил удирдсан цаг хамаарахгүй. Уг цагийг тусгайлан тооцож хөлсийг зохих

журмын дагуу олгоно. Харин нэг хичээлийн жилд нэг багш бакалаврын 5, магистрын 8 ажил удирдаж болно. Үүнээс дээш тооны ажил удирдах шаардлагатай бол мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвшөөрлөөр удирдана. 10.1.5.Суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэхдээ өөрийн сургууль болон бусад их дээд сургуулийн оюутны үнэлгээний дундажтай харьцангуйгаар (A,B,C,D,F - дүн тус бүрийн эзлэх хувь) ойртуулах зарчмыг баримталбал зохино.

10.1.6.Лекцийн нэг бүлэг (уламжлал ёсоор поток)-т хичээллэх оюутны тоо дунджаар /80-160/-аас ихгүй байхаар тооцож хичээлийг сонгосон нийт оюутны тоонд тохирсон тооны бүлэгт хуваан хичээллүүлж (бүлгүүдэд хичээллэх оюутны тоо ойролцоогоор тэнцүү байхаар зохицуулалт хийхийг зөвшөөрнө) бодит гүйцэтгэлийг багшид тооцно.

10.1.7.Бакалаврын сургалтын бүх ангиллын хичээл болон магистр, докторын сургалтын ерөнхий суурь хичээлийн лекц, семинарын хичээлд суралцагчдын тоог харгалзан үржүүлэх коэффициент хэрэглэн доорх байдлаар багц цаг тооцно. Үүнд:

Суралцагчийн тоо	0-9	10-14	15-50	51-100	101-160
Үржүүлэх коэффициент	0.7	0.8	1.0	1.2	1.4

10.1.8.Магистр, докторын сургалтын мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн лекц, семинарын хичээлд суралцагчдын тоог харгалзан үржүүлэх коэффициент хэрэглэн доор байдлаар багц цаг тооцно. Үүнд:

Суралцагчийн тоо	0-5	5-9	10-30	30+
Үржүүлэх коэффициент	0.8	0.9	1.0	1.1

10.1.9.Семинар, лаборатори, дадлагын хичээл: Магистр, докторын сургалтын ерөнхий суурь хичээл болон бакалаврын сургалтын бүх ангиллын хичээлийн семинарын бүлэгт хичээллэх оюутны тоо /40/-өөс ихгүй байх ба лабораторийн хичээлийн хувьд лабораторийн суудлын тооноос олонгүй (ректорын тушаалаар тогтооно); гадаад хэлний мэргэжлийн ангид заах ярианы дадлагын хичээлийн хувьд 20, дизайны мэргэжлийн хар, өнгөт зургийн хичээлийн хувьд 15 байхаар тооцож хичээлийг сонгосон нийт оюутны тоонд тохирсон тооны дэд бүлэгт хуваан хичээллүүлж, бодит гүйцэтгэлийг багшид тооцно.

10.1.10.Сургалтын бусад хэлбэрийн ажлыг тооцох

№	Ажлын хэлбэр	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
Бакалаврын сургалттай холбоотой үнэлгээ			
1	Бакалаврын дипломын ажилд шүүмж бичих	1 ажил	0.1
2	Бакалаврын дипломын ажлыг удирдах	1 ажил	0.2
3	Бакалаврын төгсөлтийн улсын шалгалтын нарийн бичгээр ажиллах		0.02
4	Бакалаврын төгсөлтийн улсын шалгалтын комисст ажиллахад /мөнгөөр тооцдог байсныг тэнцэх кр шилжүүлсэн/	1 оюутан	0.015
5	Оюутныг удирдаж сургалтын төлөвлөгөөнд заасан ангийн болон төслийн ажил хийлгэх (хичээлийн жилд нэг багшид 10-аас олон оюутныг	1 оюутан	0.03

	хуваарилахгүй)		
6	Мэргэжлийн болон мэргэшүүлэх багшлах, үйлдвэрлэлийн болон хээрийн, орчуулгын дадлага удирдах	1 оюутан	0.05
7	Танилцах дадлага удирдах.	1 оюутан	0.03
Магистрын сургалттай холбоотой үнэлгээ Бүгд мөнгөөр боддог байсныг харгалзах кредит шилжүүлсэн			
1	Магистрын дипломын ажил удирдах	1 ажил	0.6
2	Магистрын дипломын ажилд шүүмж бичих	1 ажил	0.2
3	Магистрын зэрэг хамгаалуулах комисст ажиллах	1 оюутан	0.025
4	Магистрын төгсөлтийн улсын шалгалтын нарийн бичгээр ажиллах	1 оюутан	0.025
5	Магистрын судалгааны тайлан удирдах	1 оюутан	0.4
6	Судалгааны семинар удирдах	1 оюутан	0.3
7	Магистрын гадаад хэлний шалгалт зохион байгуулах	1 удаа	0.2
Докторын сургалттай холбоотой үнэлгээ Бүгд мөнгөөр боддог байсныг харгалзах кредит шилжүүлсэн			
1	Докторын дипломын ажил удирдах	1 ажил	2
2	Докторын ажлын зөвлөхөөр ажиллах	1 ажил	0.07
3	Докторын урьдчилсан хамгаалалтын нарийн бичгээр ажиллах		0.08
4	Докторын урьдчилсан хамгаалалтын зөвлөлд ажиллах	1 оюутан	0.07

10.1.11.Сургалтын үйл ажиллагаатай холбоотой гарч болох зөрчлүүдийг тооцон хасах кредит

№	Агуулга	Хэмжих нэгж	Үнэлгээ Кредит
1	Хичээл шалтгаангүй таслах, тасарсан хичээлийг холбогдох албанд урьдчилан мэдэгдэлгүйгээр нөхөх	1 удаа	-0.1
2	Дүнгийн хүснэгтийг тогтсон хугацаанд хураалгахгүй байх	1 удаа	-0.1
3	Журналыг тогтсон стандартын дагуу хөтлөхгүй байх	1 удаа	-0.1
4	Элсэлтийн үйл ажиллагаанд оролцохгүй байх	1 удаа	-0.1
5	Багш нарын хурал, сургалт семинарт шалтгаангүйгээр оролцохгүй байх	1 удаа	-0.1
6	Хичээлийн цагийг шалтгаангүй, дураараа өөрчлөх	1 удаа	-0.1
7	Багшийн ёс зүйг зөрчих, сургуулийн нэр төрийг гутааж сануулга авах	1 удаа	-0.3
8	Дүн засах	1 удаа	-0.1

Багшийн ажиллах хандлагаас хамааран гарч болох зөрчлүүдэд дээрх хүснэгтийн дагуу харгалзах кредит хасаж тооцно. Багш ажиллах явцдаа элдэв зөрчилтэй асуудал гаргасан тохиолдолд анхааруулсан мэдэгдлийг Сургалтын албанаас өгнө. Багшийн албан тушаал ахихад дээрх үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ.

10.1.12. Хичээлийн жилд багшийн гүйцэтгэсэн сургалтын нийт ажлыг томъёогоор тооцно:

$$k_{\text{багш}} = k_{\text{бакалавр}} + 1.2 * k_{\text{магистр}} + 1.4 * k_{\text{доктор}} + 1.2 * k_{\text{орой}} + k_{\text{бусад}}$$

Үүнд, $k_{\text{бакалавр}}$ – бакалаврын сургалтад заасан хичээлүүдийн нийт кредит, $k_{\text{магистр}}$ – магистрын сургалтад заасан хичээлүүдийн нийт кредит, $k_{\text{доктор}}$ – докторын сургалтад заасан хичээлүүдийн нийт кредит, $k_{\text{орой}}$ – оройн сургалтад заасан хичээлүүдийн нийт кредит, $k_{\text{бусад}}$ – 10.1.10-т заасан ажлуудын хувьд тооцсон нийт кредит.

10.2. Б. Эрдэм шинжилгээ болон зохион бүтээх ажлын үнэлгээ

Эрдэм шинжилгээ (ЭШ)-ний болон аливаа зохион бүтээх ажилд зарцуулсан багшийн хөдөлмөрийг шууд үнэлэх боломжгүй учраас уг ажлын үр дүн, түүний чансаа, хэмжээг харгалзан кредитээр үнэлнэ.¹ Үүнд:

10.2.1. Эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх¹

№	Эрдэм шинжилгээний өгүүллийн төрөл	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1.	Нэр хүндтэй олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүл (SCI, SSCI, SCIE)		12
2.	Scopus, Index Medicus-д хэвлүүлэх эрдэм шинжилгээний сэтгүүл	1 өгүүлэл	10
3.	G7 улсын эрдэм шинжилгээний сэтгүүл		8
4.	Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүл ²		6
5.	Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн дотоодын сэтгүүл		4

10.2.1.6. 10.2.1.5-д заасан хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд жилд нэгээс доошгүй эрдэм шинжилгээний өгүүллийг заавал хэвлүүлнэ.

10.2.1.7. 10.2.1.1, 10.2.1.2, 10.2.1.3, 10.2.1.4-д заасан хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд гурван жилд нэгээс доошгүй эрдэм шинжилгээний өгүүллийг заавал хэвлүүлнэ.

10.2.1.8. 10.2.1.1, 10.2.1.2, 10.2.1.3, 10.2.1.4-д заасан сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн бол 10.2.1.5-д заасан шаардлагыг хангасанд тооцно.

10.2.1.9. 10.2.1.1, 10.2.1.2, 10.2.1.3, 10.2.1.4, 10.2.1.5-д заасан хянан магадалгаа хийгддэг сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлээгүй бол эрдэм шинжилгээний гүйцэтгэлийг (Б цаг) хангаагүй гэж үзнэ.

10.2.2. Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл³

№	Бүтээлийн ялгаа (тайлбар)	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
---	---------------------------	-------------	--------------

¹ Олон гүйцэтгэгч, зохиогчтой үед хэрвээ гүйцэтгэгч, зохиогчийн оролцоо тодорхой бол оролцооны хувиар нь, харин тодорхой биш бол ажлын кредитийг оролцогчдод тэнцүү хуваана. Нэг өгүүллийг хэд хэдэн сэтгүүлд хэвлүүлсэн бол аль өндөр үнэлэмжтэйгээр нь тооцно.

² Олон улсын болон гадаад улсын шинжлэх ухааны байгууллагын мэдээллийн санд бүртгэлтэй мэргэжлийн хянан магадалгаа хийгддэг эрдэм шинжилгээний сэтгүүл байна.

³ Өөр өөр шатанд хэлэлцүүлсэн нэг илтгэлийг давхардуулан кредит цаг тооцохгүй.

1	Олон улсын хурал (3 ба түүнээс дээш орны төлөөлөгч оролцсон) <ul style="list-style-type: none"> • Урилгаар оролцож хэлэлцүүлсэн • Илтгэл хэлэлцүүлж, хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн • Илтгэл хэлэлцүүлсэн • Самбарт тавигдаж хэвлүүлсэн • Самбарт тавигдсан • Илтгэлийн хураангуйд хэвлүүлсэн 	1 илтгэл	4 4 3 2 1 1
2	Улсын хэмжээний хурал (3 ба түүнээс дээш тооны байгууллага оролцсон) <ul style="list-style-type: none"> • Илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлсэн • Илтгэл хэлэлцүүлсэн • Самбарт тавигдаж хэвлэгдсэн • Самбарт тавигдсан буюу ханын илтгэл • Илтгэлийн хураангуйг хэвлүүлсэн 	1 илтгэл	2 1 1 0.5 0.5
3	Сургуулийн хэмжээний хурал <ul style="list-style-type: none"> • Илтгэл хэлэлцүүлсэн • Самбарт тавигдсан 	1 илтгэл	1 0.5
4	Салбарын хуралд хэлэлцүүлсэн	1 илтгэл	0.3
5	Салбарын мэргэжлийн ба сургалт арга зүйн семинар <ul style="list-style-type: none"> • Удирдан зохион байгуулах 	Хич. жилд 8 удаа	0.8
	<ul style="list-style-type: none"> • Илтгэл тавих 	1 илтгэл	0.2

10.2.3. Судалгааны зохиол бүтээл хэвлүүлэх

№	Бүтээлийн ялгаа (тайлбар)	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1	Нэг сэдэвт зохиол 1. Монограф ⁴	2 х.х.	3.0
	2. Засгийн газар, олон нийтийн байгууллагын судалгааны тайлан -		1.2
2	Шинжлэх ухааны докторын диссертац 1. Монгол хэлээр бичсэн	1 диссертац	10
	2. Англи хэлээр бичсэн		12
3	Доктор (Ph.D)-ын диссертац 1. Монгол хэлээр бичсэн	1 диссертац	8
	2. Англи хэлээр бичсэн		10
4	Эрдэм шинжилгээний бүтээл ⁵ 1. Олон улсын ЭШ-ний бүтээл	2 х.х.	3
	2. Дотоодын ЭШ-ний бүтээл		2

10.2.4. Оюуны өмчийн бусад бүтээл

⁴ Эрдмийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлийг тооцох бөгөөд тухайн хичээлийн 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө Эрдмийн зөвлөлд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

⁵ Дээрхтэй адил байна.

№	Бүтээлийн ялгаа (тайлбар)	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1	Сургалтын материал, ном, хэвлэл ⁶ , сургалтын орчин 1. Сурах бичиг 2. Гарын авлага (дадлагын дэвтэр, хичээлийн цахим үзүүлэн /PP/-гийн нэгтгэл орохгүй) 3. Е-ном, Е-сурах бичиг, Е-гарын авлага 4. Орчуулгын бүтээл /ном, сурах бичиг, гарын авлага/	2х.х.	2 1.5 1.5 1.2
	1. Үзэсгэлэнд тавигдсан бүтээл (Мэргэжлийн салбарын болон улсын хэмжээнд) ⁷ 2. Мэргэжлийн нэр хүндтэй сэтгүүлээс орчуулж хэвлүүлсэн өгүүлэл	1	1 0.5
	Оновчтой санал (зохиогчийн эрх авсан) ⁸ • Монголд • Гадаадад	1 бүтээл	3 5
	Зохион бүтээсэн • Программ хангамж (зохиогчийн эрх авсан) • Дизайн зохиомж (практикт нэвтрүүлсэн бүтээл) • Бүтээлийн үзэсгэлэн (Мэргэжлийн салбар, улсын хэмжээнд)	1 бүтээл 1 бүтээл 1 үзэсгэлэн	3 3 4
	Хянан тохиолдуулсан бүтээл ⁹ • Нэг сэдэвт зохиол • Мэргэжлийн сурах бичиг • Орчуулсан бүтээл Эмхлэн найруулсан бүтээл	1 х.х.	0.3 0.2 0.3 0.5
	Сургалтын кино ¹⁰ • Монгол хэлээр бичсэн • Гадаад хэлээр бичсэн	хичээл	3 5
2.	Оюуны өмчийн бүтээл 1. Шинэ бүтээл (зохиогчийн эрх авсан) ¹¹ • Монголд • Гадаадад 2. Ашигтай загвар (патент авсан) 3. Бүтээгдэхүүний загвар (патент авсан) 4. Барааны тэмдэгт	1 бүтээл	5 10 3 2 1
	5. Бусад ¹² • Толь бичиг (хариуцан хянасан) • Эмхэтгэл	1 бүтээл	2 0.5

⁶ Дээрхтэй адил байна.

⁷ Үзэсгэлэнд оролцсон тухай нотлох баримтын эх хувийг(урилга, хөтөлбөр, тайлан, бүтээл гэх мэт) заавал шалгаж эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тооцно.

⁸ Эрдмийн зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлийг тооцох бөгөөд тухайн хичээлийн 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө Эрдмийн зөвлөлд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

⁹ Дээрхтэй адил байна.

¹⁰ Дээрхтэй адил байна.

¹¹ Дээрхтэй адил байна.

¹² Дээрхтэй адил байна.

10.2.5.Эрдэм шинжилгээ болон судалгааны төсөл

№	Төрөл (тайлбар)	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1	ОУУБИС-ийн санхүүжилттэй төсөл (гүйцэтгэлийн тайлангаар) <ul style="list-style-type: none"> • Хариуцсан судлаач (удирдагч) • Гүйцэтгэгч (судлаач) 	1 ажил/ хичээлийн жил	4 3
2	ОУББИС-ийн нэрээр гэрээний дагуу хийсэн бусад байгууллагын захиалгат төсөл (гүйцэтгэлийн тайлангаар) <ul style="list-style-type: none"> • Хариуцсан судлаач (удирдагч) • Гүйцэтгэгч (судлаач) 	1 ажил/хич. жил	3 2
3	Гадаадын байгууллагатай хамтарсан, санхүүжилттэй төсөл (гүйцэтгэлийн тайлангаар) <ul style="list-style-type: none"> • Хариуцсан судлаач (удирдагч) • Гүйцэтгэгч (судлаач) 	1 ажил/хич. жил	4 3
4	Гаднын байгууллагатай хамтран ажиллах төсөл боловсруулж, сургуулийн хүрээнд хэрэгжүүлсэн <ul style="list-style-type: none"> • Хариуцсан судлаач (удирдагч) • Гүйцэтгэгч (судлаач) 	1 удаа	5 2
5	Судалгаатай холбоотой шагнал <ul style="list-style-type: none"> • Олон улсын ЭШ-ний байгууллагын шагнал • Улсын болон тухайн салбарын ЭШ-ний шагнал • Оюутныг удирдаж хэлэлцүүлсэн илтгэл бүрд 	1 удаа	1.2 1 0.2
6	Докторын судалгааны ажил удирдаж, хамгаалуулсан	1 ажил	3

10.2.6.Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, индекстэй, өндөр эрэмбийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлж, Б цагийн нормоос давсан кредит цагийг дараа жилийн Б цагт тооцуулж болно.

10.3. В. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний үнэлгээ

Оюутнуудын дунд хүмүүжил, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах, нийгэм, олон нийтэд үйлчлэх чиглэлээр багшийн хийсэн ажлыг дараах байдлаар үнэлэн тооцно.

10.3.1.Оюутанд чиглэсэн үйлчилгээ

№	Ажлын нөхцөл / хэлбэр	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1	Мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах <ul style="list-style-type: none"> • Улсын хэмжээнд • Сургуулийн хэмжээнд • Тэнхимийн хэмжээнд 	1 арга хэмжээ	1 0.8 0.5

2	Улсын хэмжээнд зохиогдох мэргэжлийн олимпиад, уралдаан тэмцээнд баг, оюутан бэлтгэж оролцох <ul style="list-style-type: none"> • 1-ээс 3 дугаар байранд шалгарах • Тусгай шагнал авах • Оролцох 	1 арга хэмжээ	0.8 0.5 0.2
3	Гадаад хэлний баяр, урлаг, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах <ul style="list-style-type: none"> • Улсын хэмжээнд • Сургууль, салбарын хэмжээнд 	1 арга хэмжээ	0.5 0.2
4	Улсын хэмжээнд зохиогдох урлаг, спортын уралдаан тэмцээнд сургуулийн баг, оюутан бэлтгэж оролцох <ul style="list-style-type: none"> • 1-ээс 3 дугаар байранд шалгарах • Тусгай шагнал авах • Оролцох 	1 арга хэмжээ	0.5 0.3 0.1
5	Соёл, олон нийтийн ажил: <ul style="list-style-type: none"> • Олон улс болон улсын хүрээнд, сайн дурын ажил зохион байгуулах • Олон улс болон улсын хүрээнд, сайн дурын ажилд оролцох • Сургуулийн хүрээнд тусламж, сайн дурын ажил зохион байгуулах • Сургуулийн хүрээнд тусламж, сайн дурын ажилд оролцох 	1 ажил	0.8 0.2 0.5 0.2
6	Дугуйлан удирдан хичээллүүлэх	1 удаа	0.5
7	Оюутанд зөвлөгөө өгөх <ul style="list-style-type: none"> • Оюутныг ажлын байранд зуучлах • Оюутанд зөвлөгөө өгөх (тэмдэглэл хөтлөх) 	1 оюутан	0.2 0.1
8	Оюутан элсүүлэх	1 оюутан	0.5
9	Сургуулийн хэмжээний урлаг, спортын өдөрлөгт оюутан бэлтгэж оролцуулах	1 удаа	0.2
10	Сургууль сурталчлах ажил: <ul style="list-style-type: none"> • Хөдөө орон нутагт ажиллах, • Улаанбаатар хотод ажиллах 	1 удаа	0.5 0.2
11	Тэтгэлгийн санд мөнгөн хандив оруулах: <ul style="list-style-type: none"> • 300,000-1,000,000 төгрөг • 1,010,000-1,500,000 төгрөг • 1,510,000-2,000,000 төгрөг • 2,010,000-2,500,000 төгрөг • 2,510,000-3,000,000 төгрөг • 3,010,000-3,500,000 төгрөг • 3,510,000-4,000,000 төгрөгөөс дээш Сургуулийн эд хөрөнгө, сургалтын баазад материаллаг зүйл хандивлах: <ul style="list-style-type: none"> • 300,000-1,000,000 төгрөг • 1,010,000-1,500,000 төгрөг • 1,510,000-2,000,000 төгрөг • 2,010,000-2,500,000 төгрөг 	1 хүний тоо	0.2 0.5 0.8 1.1 1.4 1.7 2 0.2 0.5 0.8 1.1 1.4

	<ul style="list-style-type: none"> • 2,510,000-3,000,000 төгрөг • 3,010,000-3,500,000 төгрөг • 3,510,000-4,000,000 төгрөгөөс дээш 		1.7 2
--	--	--	----------

10.3.2.Сургууль доторх үйлчилгээ

№	Ажлын хэлбэр (тайлбар)	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1	Сонгуульт ажил <ul style="list-style-type: none"> • Захиргааны зөвлөлийн гишүүн • Эрдмийн зөвлөлийн гишүүн • Эрдэмтэн нарийн бичгийн дарга, эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга • Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн комиссын гишүүн • Ёс зүйн хорооны гишүүн • Яам агентлагийн ажлын хэсэгт гишүүн • Байнгын (дээрхээс бусад) зөвлөл, комиссын гишүүн 	1 жилд	1 0.5 0.8 1 0.8 0.4 0.2
2	Ректорын шийдвэрээр дүрэм заавар, зөвлөмж болон бусад баримт бичиг боловсруулах	Хэмжээнээс шалтгаалан	1
3	Сургалтын алба, тэнхимийн даалгавраар багшийн хичээлд сууж зөвлөгөө өгөх буюу дагалдуулан сургах	1 цаг	0.03
4	<ul style="list-style-type: none"> • Томилолтоор гадаадад явах, guide болон орчуулга хийх • Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах, удирдах зөвлөлийн даалгаврыг гүйцэтгэх • Сургуулийн шаардлагатай дүрэм, журам, бичиг баримтыг орчуулах • Сургуулийн багш, ажилчдад зориулсан тусламжийн ажил 	Үндсэн ажлаас бусад нэмэлт ажил	0.2 0.2 0.2 0.2
5	Зөвлөх багшаар ажиллах	хич. жилд	1+(n-30)*0.03
6	Бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчээр ажиллах		2кр

10.3.3.Олон нийтэд чиглэсэн үйлчилгээ

№	Ажлын хэлбэр (тайлбар)	Хэмжих нэгж	Үнэлгээ (кр)
1	Хурал, семинар зохион байгуулах <ul style="list-style-type: none"> • Олон улсын хэмжээнд • Улсын хэмжээнд • Багш нарын ЭШ-ний хурал зохион байгуулсан (сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд) • Оюутны ЭШ-ний хурал зохион байгуулсан (сургууль, бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд) 	1 хурал	1 0.5 0.4 0.3
2	Урилгаар лекц унших	1 лекц	

			0.2
3	Радио, телевизийн нэвтрүүлэгт оролцож сургууль, мэргэжил сурталчлах	1 нэвтрүүлэг	0.5
4	Тусгай ажлын хэсгийн гишүүнээр ажиллах	1 удаа	0.5

Арван нэг. Багшийн ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх ба хянах

11.1. Жил бүрийн 5-р сард хичээл сонголтын урьдчилсан дүн гарсны дараа ирэх хичээлийн жилд багшийн гүйцэтгэх нийт ажлыг тэнхимийн эрхлэгч гаргаж, Сургалтын албаар хянуулна. Заадаг хичээл, албан тушаалын зэрэглэлийг нь тооцон багш нарт сургалтын ажлыг жигд хуваарилсан байх шаардлагатай бөгөөд зайлшгүй тохиолдолд багшийн нормын 6 кредитийн хичээлийг илүү заалгахаар төлөвлөж болно. Харин багшийн кредит норм хүрэхгүй тохиолдолд тухайн багшид хуваарилсан кредит нормын хэмжээгээр багшийг хувилж ажиллуулна. Багшийн жилд гүйцэтгэх цагийн ачааллыг төлөвлөсөн тохиолдолд хөдөлмөрийн гэрээ хийнэ. Хичээлийн жилийн явцад өвдсөн, ажил өөрчлөгдсөн, гадаад, дотоодод томилолтоор ажилласан багшийн хичээлийг Сургалтын албаны зөвшөөрлөөр өөр багшид шилжүүлэн илүү цаг гүйцэтгүүлж болно. Зайлшгүй шаардлагаар илүү заах зөвшөөрөгдсөн нормоос давсан кредитийн хичээл заах болбол зөвхөн магистр, докторын хөтөлбөрт ректорын тушаалаар заахыг зөвшөөрнө. Багш хүрэлцэхгүй байгаа үед цагийн мэргэжлийн багшийг ажиллуулж болно.

11.2. Хичээлийн жилийн төгсгөлд багш нарын ажлын гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч хэсэг тус бүрээр нь тооцож гаргах бөгөөд *A* хэсгийн гүйцэтгэлийг Сургалтын алба; *B* хэсгийн гүйцэтгэлийг Эрдэм шинжилгээний алба; *B* хэсгийн гүйцэтгэлийг Оюутны алба тус тус дүгнэж баталгаажуулна. Багш нарын 1 жилийн нийт ажлын гүйцэтгэлийг ректор хянан баталгаажуулна.

11.3. Багш бүр ажиллаж байгаа албан тушаалын дагуу энэ журмын 9.3-т заасан кредитийн сургалт (*A*), эрдэм шинжилгээ (*B*), нийгмийн үйлчилгээний (*B*) ажлыг заавал биелүүлэх үүрэгтэй.

11.4. Хичээлийн жилийн эцэст багшийн гүйцэтгэлийг үнэлж, гүйцэтгэлийн урамшуулал олгоно. Урамшууллыг дараах аргачлалаар бодож олгоно. Үүнд:

11.4.1. Сургалт (*A*)-ын ажлын үнэлгээ 20 оноо, эрдэм шинжилгээ (*B*)-ний ажлын үнэлгээ 40 оноо, нийгмийн үйлчилгээний (*B*) ажлын үнэлгээ 20 оноо, оюутны үнэлгээ 10 оноо, тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ 5 оноо, салбар сургуулийн захирлын үнэлгээ 5 оноо, нийт 100 оноо байна.

11.4.2. Тэнхимийн эрхлэгчийг салбар сургуулийн захирал, салбар сургуулийн захирлыг ректор үнэлнэ. Тэнхимийн эрхлэгч, салбар сургуулийн захирал, ректорын үнэлгээний шалгуур, аргачлалыг холбогдох албан тушаалтан, нэгжүүд харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдэж, үнэлгээг хичээлийн жилийн эцэст Сургалтын албанд өгнө. Профессор багшийн гүйцэтгэлийн нийт үнэлгээг Сургалтын алба 11.4.1-д заасан аргачлалын дагуу тооцож, үр дүнг хичээлийн жилийн эцэст Захиргаа, хүний нөөцийн албанд хүлээлгэн өгнө.

11.4.3. Тус журмын 11.4.1-д заасан аргачлалын дагуу багшийн гүйцэтгэлийг үнэлэх бөгөөд урамшууллын шатлал нь дараахтай адил байна.

91-100 оноо: 100% урамшуулал,

81-90 оноо: 80% урамшуулал,

71-80 оноо: 60% урамшуулал,

70-аас доош оноо: урамшуулал олгохгүй.

11.5. Докторын (боловсрол болон шинжлэх ухааны) зэрэг хамгаалахаар диссертац бичиж байгаа багшийн хувьд *A* хэсгийн 2 хүртэлх кредитийг, *B* хэсгийн илүү

гүйцэтгэсэн 1.5 кредитийг А хэсгийн 1 кредиттэй дүйцүүлэн нөхөн тооцож болно. Харин В хэсгээс А, Б-д шилжүүлэн тооцохгүй. Мөн эрдмийн зэрэг горилохоор ажиллаж буй докторант эрдэм шинжилгээний ажлынхаа 75-аас доошгүй хувийг гүйцэтгэсэн, харьяалах зөвлөлөөс дүгнэлт гарсан тохиолдолд докторантын өөрийн хүсэлтээр 1 сар хүртэл цалинтай чөлөөг ректорын тушаалаар олгоно.

11.6. Илүү болон дутуу гүйцэтгэсэн ажлын хөлс тооцох нөхцөл:

11.6.1. Багшийн төлөвлөсөн ажлын А хэсгийн гүйцэтгэл нормоос давсан бол илүү кредитэд харгалзах хөлс олгох ба харин дутуу биелүүлсэн бол дутсан кредитэд ноогдох цалинг буцаан төлүүлэх буюу ээлжийн амралтын олговроос суутгана. *Багшийн зэрэглэлээс үл хамааран нэг кредит цагийн үнэлгээг 390000 төгрөгөөр тогтооно. Үүнийг "Багшийн нэг кредит цагийн үндсэн үнэлгээ" гэнэ.*

11.6.2. Тогтсон хэмжээнээс илүү хичээлийг дадлагажигч багшид хуваарилж заалгахыг хориглоно.

11.6.3. Үндсэн багш хичээлийн жилд 5 хүртэлх кредитийн илүү цаг зааж болох ба багшийн нормоос давсан 5 кредит хүртэлх кредит цагийн хөлсийг үндсэн үнэлгээгээр бодож олгоно.

11.6.4. Зайлшгүй шаардлагаар сургуулийн захиргааны шийдвэр гарч 5 кредитээс илүү заасан тохиолдолд кредит цагийн хөлсийг 300000 төгрөгөөр бодож олгоно.

11.6.5. Багш нарын жилийн ажлын гүйцэтгэлийг урьдчилан тооцож, боломжтой гэж үзвэл 1-р улиралд гүйцэтгэсэн илүү кредитийн хөлсний тодорхой хувийг тухайн үед нь олгож болно.

11.6.6. А хэсгийн гүйцэтгэлээс дутсан цагийг багшийн нэг кредитийн үндсэн үнэлгээгээр бодож суутгана.

11.7. Багшийн ажлын Б цаг гүйцэтгэлийн дутсан тохиолдолд А цагийн 1 кредитийг энэхүү журмын 9.3-т заасан багшийн зэрэглэлд харгалзуулан дараах үржвэрийн коэффициентоор дүйцүүлэн, төлүүлэх буюу ээлжийн амралтын олговроос суутгаж тооцно.

№	Багшийн зэрэглэл	Үржвэрийн коэффициент (А цаг)	Үржвэрийн коэффициент (Б цаг)
1	Профессор	1.0	5.0
2	Дэд профессор	1.0	4.0
3	Ахлах багш	1.0	3.0
4	Багш	1.0	2.0
5	Дадлагажигч багш	1.0	0

(Жишээ нь: профессор багшийн Б цагаас 5 кр дутвал А цагаас 1 кр хасах гэх мэт)

11.8. Проректор, алба, хэлтэс, төвийн даргын үүрэгт ажилд томилогдон ажиллаж буй профессор багш нар хичээлийн жилд бакалаврын өдрийн сургалтад 2-6 кр-ийн хичээлийг зааж болох бөгөөд нэмэлт цагийн хичээл орж болохгүй. Магистр, доктор болон оройн ангид хичээл зааж, судалгааны ажил удирдаж болно. Ажлын гүйцэтгэлийн хөлсийг бусад багш нарын адил тооцно.

11.9. Багш захиргааны албан тушаалд томилогдон ажилласан тохиолдолд ажилласан хугацааг багшилсан хугацаанд дүйцүүлэн тооцно. Томилогдон ажиллах хугацаанд багшийн мэргэжлийн тэнхимд заах хичээл болон ажлын байрыг хадгална.

11.10. Бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчийн хичээлийн жилд гүйцэтгэх А цаг буюу сургалт, заах арга зүйн кредит нормоос 2 кредитийг чөлөөлж, В цаг буюу нийгмийн үйлчилгээний цаг дээр нэмэгдүүлнэ.

11.11. Хөтөлбөрөө амжилттай магадлан итгэмжлүүлсэн өөрийн үнэлгээний тайлан бичсэн багт дараах сургалтын кредит тооцно. Үүнд:

11.11.1. Урьдчилсан магадлан итгэмжлэлд хөтөлбөрөө магадлуулж, шинэ хөтөлбөр нээсэн бол тухайн багт 8 кр, хэрэгжиж буй хөтөлбөрөө амжилттай магадлуулсан багт 5 кр тус тус тооцно.

11.11.2. Багш нар мэргэжлийнхээ дагуу бусад сургуулийн урилгаар, үндсэн сургалтын ажилд нөлөөлөхгүй хэмжээний (2-3кредит) цагийн хичээл заахыг тэнхимийн эрхлэгч, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

Арван хоёр. ОУУБИС-ийн багшид профессор, дэд профессор цол олгох

12.1. ОУУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр сургуулийн профессор, дэд профессор цолыг олгоно.

12.1.1. ОУУБИС-ийн эрдмийн цол нь профессор, дэд профессор гэсэн шатлалтай байна.

12.1.2. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багшилсан, ажилласан хугацаа, сургалтын ажлын туршлага, эрдэм шинжилгээний бүтээлийг нь харгалзан докторын зэрэгтэй багш, ажилтанд 12.2-д заасан болзлыг хангасан тохиолдолд ОУУБИС-ийн профессор цол олгоно.

12.1.3. Энэхүү журмын 12.3 – д заасан болзлыг хангасан багш, ажилтанд ОУУБИС-ийн дэд профессор цол олгоно.

12.1.4. Дэд профессор цол хүртсэнээс хойш 3-аас доошгүй жилийн дараа профессор цолд, докторын зэрэг хамгаалснаас хойш 2-оос доошгүй жилийн дараа дэд профессор цолд нэр дэвших эрх нээгдэнэ.

12.1.5. Профессор, дэд профессор цолд нэр дэвшээд ОУУБИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийн олонхын санал авч чадаагүй тохиолдолд 2 жилийн дараа дахин нэр дэвших эрх нээгдэнэ.

12.1.6. ОУУБИС-ийн профессор, дэд профессор цолд нэр дэвшигчийн баримт бичгийг хичээлийн жилд 1 удаа хүлээн авч хэлэлцэнэ.

12.2. Цол олгох болзол

12.2.1. Профессор цолыг дараах болзлыг хангасан иргэнд олгоно.

12.2.2. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан, үүнээс ОУУБИС-д 8-аас дээш жил багшилсан, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой байх;

12.2.3. Дэд профессор цол хүртээд 3-аас доошгүй жил болсон байх;

12.2.4. Нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага бичиж нийтлүүлсэн байх;

12.2.5. Гадаад болон дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 30-аас доошгүйг, дэд профессор цол хүртсэнээс хойш 6-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх /хэрэв шинжлэх ухааны доктор бол зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх/;

12.2.6. Эрдэм шинжилгээний төслийн тайлан, патент, барааны тэмдэг, ашигтай загвар, зохиогчийн эрхийн гэрчилгээ 5-аас доошгүйг авсан байх;

12.2.7. Хоёроос доошгүй горилогчийн эрдэм шинжилгээний ажлын удирдагч буюу зөвлөхөөр томилогдон ажиллаж докторын зэрэг хамгаалуулсан, 10-аас доошгүй магистрын ажил удирдсан байх;

12.2.8. Урлагийн чиглэлийн багш нарын туурвисан урлагийн зарим бүтээлийг эрдэм шинжилгээний бүтээлд тооцож болно.

12.2.9. Үндэсний болон олон улсын түвшний төслийн удирдагч болон хэрэгжүүлэгчээр ажилласан байх

12.2.10. Нийгэм болоод тухайн салбарын хөгжилд шаардлагатай төслийг санаачилж, санхүүжилт босгон хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах;

12.3. Дэд профессор цолыг дараах болзлыг хангасан иргэнд олгоно.

12.3.1. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан, үүнээс ОУУБИС-д 5-аас доошгүй жил багшилсан, докторын зэрэгтэй байх;

- 12.3.2. Докторын зэрэг хамгаалаад 2-оос доошгүй жил болсон байх;
- 12.3.3. Нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага бичиж нийтлүүлсэн байх;
- 12.3.4. Гадаад болон дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 15-аас доошгүйг, үүнээс докторын зэрэг хамгаалснаас хойш 5-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх;
- 12.3.5. Эрдэм шинжилгээний төслийн тайлан, патент, барааны тэмдэг, ашигтай загвар, зохиогчийн эрхийн гэрчилгээ 2-оос доошгүйг авсан байх;
- 12.3.6. Мэргэжлийн хичээл заах ур чадвараар суралцагчдаасаа өндөр үнэлгээ тогтмол авдаг, сургалтын баримт бичиг боловсруулах, сургалтад бүтээлч санаачилгатай оролцдог байх;
- 12.3.7. 5-аас доошгүй магистрын ажил удирдаж хамгаалуулсан байх;
- 12.3.8. Урлагийн чиглэлийн багш нарын туурвисан урлагийн зарим бүтээл, спортын чиглэлийн багш нарын гаргасан спортын амжилтыг эрдэм шинжилгээний бүтээлд тооцож болно.
- 12.3.9. Үндэсний болон олон улсын түвшний төслийн удирдагч болон хэрэгжүүлэгчээр ажилласан байх;
- 12.3.10. Нийгэм болоод тухайн салбарын хөгжилд шаардлагатай төслийг санаачилж, санхүүжилт босгон хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах;

12.4. Нэр дэвшүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

12.4.1. Профессор, дэд профессор цолд нэр дэвшүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

12.4.2. Нэр дэвшүүлсэн тэнхим, нэгжээс нэр дэвшүүлсэн тодорхойлолт /Тодорхойлолтод дараах зүйлсийг заавал тусгана./

- Нэр дэвшигчийн тухайн үед ажиллаж байгаа албан тушаал, уг албан тушаалд хэд дэх жилдээ ажиллаж байгаа, докторын зэргийг хаана, хэдэн онд хамгаалсан, дээд боловсролын байгууллагад болон нийт хэдэн жил ажилласан хугацаа, эрдэм шинжилгээ судалгаа, шинэ бүтээл, патент, барааны тэмдэг, ашигтай загвар, тэдгээрээс хэвлэн нийтлүүлсэн, нэвтрүүлсэн ажлын тоо хэмжээ;
- Хэвлэн нийтлүүлсэн болон шинэ бүтээл, патент, барааны тэмдэг, ашигтай загвар, зохиогчийн эрх авсан, практикт нэвтрүүлсэн 2-3 бүтээл;
Нэр дэвшигчийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, багшлах ур чадвар, мэргэжлийн чиглэлийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцдог байдал;
- Нэр дэвшүүлж буй үндэслэл.

12.4.3. Нэр дэвшигчийн товч намтар (анкет);

12.4.4. Нэр дэвшигчийн удирдаж хамгаалуулсан магистр болон докторын нэрс, тэдгээрийн диссертацийн нэр, ажлын албан ёсны шүүмжлэгчээр ажилласан тухай тодорхойлолт, жагсаалт;

12.4.5. Профессор цолд нэр дэвшиж буй бол дэд профессор цол олгосон шийдвэрийн хуулбар, дэд профессор нэр дэвшигчийн хувьд магистрын болон докторын дипломын хуулбар;

12.5. Бүтээлийн жагсаалт.

12.5.1. Профессор, дэд профессор цол олгох;

12.5.2. Профессор, дэд профессор цол олгохтой холбоотой нэр дэвшигчийн болзол хангасан баримт бичгийг Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга холбогдох тэнхим, нэгжээс хүлээн авч, эрдмийн зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлнэ.

12.5.3. Эрдмийн зөвлөлийн хуралдаанд нийт гишүүдийн олонх оролцсон бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

12.5.4. Профессор, дэд профессор цол олгох асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

12.5.5.Хуралдаанд оролцсон Эрдмийн зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар профессор, дэд профессор цол олгохоор шийдвэрлэсэн нөхцөлд Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн сургуулийн захирлын тушаалаар цол олгоно.

12.5.6.ОУУБИС-д ажиллаж байгаа багш, ажилтанд профессор, дэд профессор цолны нэмэгдлийг сургуулийн холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

12.6.Бусад заалт

12.6.1.Эрдмийн зөвлөлд ОУУБИС-ийн аль ч тэнхим, нэгжээс багш, ажилтныг нэр дэвшүүлж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэх боломжтой.

12.6.2.Профессор, дэд профессор цол олгохтой холбоотой санал гомдлыг Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч, Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

12.6.3.Профессор, дэд профессор цолыг зохих шаардлага журмыг зөрчин олгосон нь нотлогдвол Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн сургуулийн ректорын тушаалаар цолыг хүчингүй болгоно.

12.6.4.Сургуулийн профессор, дэд профессор цол олгосон тухай шийдвэрийг сургуулийн багш, оюутнуудад ил тод нээлттэй танилцуулж, үнэмлэхийг гардуулна.

12.6.5.Сургуулийн профессор, дэд профессор цолны үнэмлэхийг ОУУБИС-аас баталсан загварын дагуу үнэт цаасан дээр хэвлүүлж, сургуулийн нэгдсэн бүртгэл дугаарт оруулна.

Арван гурав. Зөвлөх багш ажиллуулах

13.1.Сургалтын кредит тогтолцооны үед оюутан бүр өөрийн сурах үйл ажиллагааг төлөвлөх, мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүдийг зөв дэс дараатай сонгох, нийт суралцах хугацааныхаа ачааллыг тохируулах, суралцах үедээ хуримтлуулсан кредит, сурлагын үзүүлэлтээ тооцон шалгаж, түүний үр дүнгээс хамааран суралцах төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулах зэрэгт оюутанд суралцах хугацааных нь турш туслах багшийг “зөвлөх багшаар” томилон ажиллуулна.

13.1.1.Оюутан суралцах хугацааны турш зөвлөх багшаасаа зөвлөгөө авч, асуудлыг хамтран шийдвэрлэж байна.

13.1.2.Оюутан нь сургалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлаар хамгийн түрүүнд өөрийн зөвлөх багшид хандвал зохино.

13.1.3. Оюутан бүрд буюу тухайн ангид зөвлөх багшийг харьяа мэргэжлийн тэнхимээс томилон ажиллуулна.

13.1.4.Зөвлөх багш нь хариуцсан оюутнууддаа нэгэн ижил шаардлага тавьж ажиллана.

13.1.5.Элссэн оюутныг төгсөх хүртэл нь зөвлөх багш хариуцан, улирал бүрээр хичээлийн сонголт, гүнзгийрүүлж судлах хичээлд зөвлөгөө өгч ажиллана.

13.2. Зөвлөх багшийн үүрэг

13.2.1.Сургалтын кредит тогтолцооны үед сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад Зөвлөх багшийн үүрэг маш чухал байна.

13.2.2.Мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний бүтэц, заавал болон сонгон судлах хичээлүүд, хичээлүүдийн холбоо дараалал, хуримтлуулах нийт кредитийн доод хязгаарыг нарийн мэдэж оюутанд зөвлөх

13.2.3.Сургалтын кредит тогтолцоог бүхэлд нь тайлбарлах, ОУУБИС-д хэрэгжүүлж байгаа тогтолцооны онцлог ялгааг ойлгуулах, энэ онцлог талын үр дагавар, түүнийг ашиглах арга замыг оюутанд зөвлөх

13.2.4.Оюутан суралцах хугацаагаа төлөвлөх болон улирал бүрийн хичээл сонголтыг оновчтой зөв хийхэд нь зөвлөх, хянах. Улиралд 12-18 кредитийн

ачаалалтай суралцахаар хичээл сонголтыг хийлгэх

13.3. Оюутанд хичээлийн хуваарь хийхэд нь зөвлөж туслах

- 13.3.1. Улирал бүрийн төгсгөлд өөрийн оюутан бүрийн сонгож судалсан хичээлүүдийн дүнгээр улирлын голч дүн болон суралцсан нийт хугацааны үзүүлэлтийг тооцож байх.
- 13.3.2. Сургалтын явцад оюутны зарцуулсан хөдөлмөр, эзэмшсэн мэдлэгийг үнэлэх системийг тайлбарлан ойлгуулах
- 13.3.3. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан дээд боловсролын агуулгыг эзэмшиж төгсөхөд тавьдаг шаардлагыг ойлгуулах, тэдгээрийг тухайн оюутан хангаж байгаа эсэхийг хянаж байх
- 13.3.4. Сургуулиас гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрийг оюутанд шуурхай хүргэх
- 13.3.5. Сургалтын үйл ажиллагааны хүрээнд оюутны дотнын туслагч, зөвлөгч нь байх
- 13.3.6. Оюутны суралцах идэвх, урам зоригийг өрнүүлэн дэмжих
- 13.3.7. Оюутан улирал, жилийн чөлөө аваад буцаж ирэх тохиолдолд үргэлжлүүлэн зөвлөх буюу дараагийн багшид албан журмаар хүлээлгэн өгдөг байх

13.4. Зөвлөх багшийн эрх

- 13.4.1. Оюутнуудын гаргасан, сургуулийн эрх зүйн хүрээнд шийдэж болох санал хүсэлтийг сургуулийн удирдлага, холбогдох алба, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх
- 13.4.2. Өөрийн хариуцсан оюутнуудыг тэтгэлэг болон шагнал урамшуулалд тодорхойлох
- 13.4.3. Төгсөх ангийн болон төгссөн оюутанд суралцаж байсан хугацааны зан байдлын тодорхойлолт бичиж өгөх
- 13.4.4. Профессор, багш ажиллуулах журамд заасны дагуу зөвлөх багшийн ажлын гүйцэтгэлийг тооцуулах эрхтэй.

Арван дөрөв. Багшийн ажлын нэгдсэн үнэлээ буюу аттестатчилах

14.1. Багшийг аттестатчилах зарчим

- 14.1.1. ОУУБИС-ийн дадлагажигч багш, багш, ахлах багш, дэд профессор, профессор зэрэглэлд ажиллаж байгаа багш нарыг 3 жил тутамд аттестатчилна.
- 14.1.2. Багш ОУУБИС-д ажилласан эхний 15 жилд 3 жил тутамд, 15-аас дээш жилд 5 жил тутамд энэ журмын дагуу ажлаа үнэлүүлнэ. Аттестатчилалд ОУУБИС-д үндсэн орон тоогоор болон 30, 50, 70 хувиар ажилладаг гэрээт багш хамрагдана. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 20 болон түүнээс дээш жил ажилласан ОУУБИС-ийн профессорууд зэрэглэлд ажилладаг багшийг өөрийн үнэлгээний тайлан бичүүлж аттестатчилна. Дадлагажигч багш ажлаа үнэлүүлэн багшаар томилогдсоныг аттестатчилалд орсонд тооцно.
- 14.1.3. ОУУБИС-ийн багшийг аттестатчилах комиссын бүрэлдэхүүнийг дэд профессор, профессор зэрэглэлд ажиллаж буй багш нарын бүрэлдэхүүнтэйгээр жил бүр ректорын тушаалаар шинэчлэн тогтооно.
- 14.1.4. Багшийг аттестатчилах үйл ажиллагааг багшийн ажлын байр, албан тушаалын зэрэглэлд ажиллах гэрээний хугацаанд хийнэ. Энэ нь ОУУБИС-ийн нийт багшийн зайлшгүй гүйцэтгэвэл зохих үүрэгт ажлыг үнэлж, тэдний чадвар чансааг тогтооход чиглэнэ.

14.1.5.Багшийн аттестатчилал нь багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох, хөдөлмөрийн гэрээг сунгах, цалин хөлс нэмэх, шагнал урамшуулалд дэвшүүлэх зэрэгт гол үндэслэл болно.

14.1.6.Үнэлгээ нь үнэн зөв, шударга, бусдаас хараат бус, бодитой, хийсэн ажлын тоо чанарын хувьд нарийн ялгаж үнэлэхүйц, найдвартай, ил тод, зардал чирэгдэлгүй байхад чиглэнэ.

14.1.7.Багш өөрийн хийж гүйцэтгэсэн үндсэн ажлаа үнэн зөв үнэлүүлэх үүднээс өөрийн үнэлгээний тайлан бичиж, нотлох баримтуудыг хавсаргасан байна.

14.1.8.Багш тэнхимийн эрхлэгчид тайлангаа өгөх бөгөөд тэнхим нь багшийн ажилд өгсөн үнэлгээгээ хурлын тэмдэглэлээр гаргаж, тайлангийн материалд хавсаргана.

14.1.9.Атестатчилалын комисс нь үнэлгээг хийхдээ тэнхимийн үнэлгээ, багшийн өөрийн үнэлгээний тайлан болон нотлох баримтад үндэслэхийн зэрэгцээ шаардлагатай алба, хэлтсүүдээс мэдээ баримт гаргуулж үндэслэнэ. Энэ нь хөдөлмөрийн гэрээ болон ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг харуулах үнэлгээ болно.

14.1.10.Багшийн аттестатчиллын үнэлгээ нь дээд боловсрол олгох үйл ажиллагааны хүрээнд багш нарын сургалт, эрдэм шинжилгээ заах арга зүйн ажлын чанарыг сайжруулах, хянах, үнэлэх, хөгжүүлэх бие даасан үнэлгээ юм.

14.2.Багшийг аттестатчилах ажлын үнэлгээний агуулга, аргачлал

14.2.1.Багшийн өөрийн үнэлгээний тайланд үндэслэн ажлыг үнэлж дүгнэх үйл ажиллагааг жил бүрийн 6-р сарын 15-ны дотор зохион байгуулж, тухайн жилд аттестатчилалд орж байгаа багш нэг бүрийн нэгдсэн үнэлгээг гаргана.

14.2.2.Тэнхимийн эрхлэгч нь багшийн үндсэн үүрэг бүрд өөрийн үнэлгээг жилийн турш өгч явах бөгөөд аттестатчилалд орох багшийн өөрийн үнэлгээний тайланд нэгтгэж хавсаргана.

14.2.3.Багшийн ажлын нэгдсэн үнэлгээ

Багшийн ажлыг дараах 3 чиглэлээр үнэлнэ. Үүнд:

- а) Сургалт, заах арга зүй;
- б) Эрдэм шинжилгээний ажил;
- в) Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ.

Багшийн нийт гүйцэтгэвэл зохих үүрэгт ажлыг 100 оноогоор дүгнэх бөгөөд багшийн албан тушаалын зэрэглэлээс хамаарч үндсэн 3 чиглэлээр онооны хуваарилалт нь дараах хүснэгтэд заасан хэмжээтэй байна.

14.2.4.Багшийн албан тушаалын зэрэглэл, гүйцэтгэх үндсэн ажилд харгалзах оноо

Багшийн албан тушаалын зэрэглэл	Сургалт, заах арга зүй	Эрдэм шинжилгээ	Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ
Профессор	30	40	30
Дэд профессор	35	35	30
Ахлах багш	40	30	30
Багш	45	25	30

14.2.5. Тооцоог гаргахдаа үзүүлэлт тус бүрээр авсан оноог 100 оноотой дүйцүүлж арифметик дунджийг гарган багцуудын харгалзах оноонд хувиан шилжүүлж тэдгээрийн нийлбэрээр \100 оноо\ гаргана. Багшийг ажилд сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ гэсэн 3 чиглэлээр үнэлгээ өгөхдөө дараах аргачлалаар өгнө.

Багшийн ажлын үнэлгээний арга :

- Өөрийн үнэлгээний тайлан;
- Оюутны үнэлгээ;
- Комиссын үнэлгээ;
- Мэргэжлийн удирдлагын үнэлгээ гэсэн хүрээгээр явуулна.

Жишээг хүснэгтэд харуулав.

Багшийн албан тушаалын зэрэглэл	Сургалт, заах арга зүй	Эрдэм шинжилгээ	Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ
Ахлах багш \авах онооны дээд утга\	40	30	30
Оюутны үнэлгээ	30	-	-
Атестатчилалын комиссын үнэлгээ	35	30	25
Тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ	40	35	25
Нийт	$30+35+40=105:3=35$	$30+35=65:2=32$	$25+25=50:2=25$

Тухайн багшийн хувьд

Оюутны үнэлгээ-35

Комиссын үнэлгээ-32

Мэргэжлийн удирдлагын үнэлгээ-25

Нийлбэр оноо $35+32+25=92$

14.2.6. Багш нь хийж гүйцэтгэсэн ажлаа үнэн зөв үнэлүүлэх үүднээс дэлгэрэнгүй тайлан бичиж, нотлох баримтуудыг хавсаргана. Багшийн ажлыг комисс, мэргэжлийн удирдлага үнэлэхдээ тайлан, хавсаргасан материалд голлон үндэслэнэ. Оюутны үнэлгээг сүүлийн 3 жилийн санал асуулгын дунджаар гаргана. Оюутны санал асуулгыг сургалтын албанаас боловсруулсан үлгэрчилсэн асуулгын хуудсаар авна.

14.2.7. Оюутны үнэлгээгээр багш 3.0.-аас доош оноо авсан тохиолдолд эхний удаад албан шаардлага сануулга өгнө.

14.2.8. Оюутны үнэлгээгээр багш 2 дахь удаагаа 3.0.с доош оноо авсан бол хөдөлмөрийн гэрээний дагуу цалингийн шатлал бууруулах арга хэмжээ авна.

14.2.9. Оюутны үнэлгээгээр багш 3 дахь удаагаа 3.0-аас доош хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд хөдөлмөрийн хуулийн дагуу гэрээг дуусгавар болгох болно.

14.2.10. Эхний 3 байр эзэлсэн багшид (30.с дээш оюутанд хичээл заасан тохиолдолд) мөнгөн урамшуулал олгоно.

14.2.11. Мөн эхний 3 байр эзэлсэн багшийг нээлттэй хичээл заалгаж бусдадаа заах арга барилаа хуваалцаж танилцуулна.

14.2.12. Урлаг, дизайн, биеийн тамирын багш нарын үнэлгээг харьяалах нэгжийн саналыг үндэслэн энэ журамд зааснаас өөрөөр хийж болно.

14.3. Багшийн ажлын үр дүнг тооцох

Атестатчилал нь тодорхой хугацаанд багшийн хийж гүйцэтгэсэн ажлын бүтээл, үр дүнг үнэн бодитой үнэлэх замаар түүний үйл ажиллагааны ололт, дутагдал,

цаашид удирдлага болон багшийн зүгээс анхаарах асуудлуудыг илрүүлэн гаргах чухал арга хэрэгсэл болохын хувьд энэ ажлын үр дүн нь багшийг дэмжиж урамшуулах эсвэл хариуцлага тооцох үндсэн шалгуур юм.

14.3.1.A(90-100): Ийм үнэлгээ авсан багшийн ажлын үр дүнг хангалттай сайн гэж үзнэ. Уг багшид зохих урамшуулал олгох ба асуудлыг бүрэлдэхүүн/салбар сургуулийн Эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.

14.3.2.B(80-89): Эрхэлсэн ажилдаа тэнцэж байна гэж үзнэ.

14.3.3.C(70-79): Ажилдаа тэнцэж байна гэж үзэх боловч тухайн багшид бага оноо авсан ажлын үзүүлэлтээ сайжруулах хугацаатай даалгавар өгнө.

14.3.4.D(60-69): Ажлын үзүүлэлт хангалтгүй гэж үзэх ба албан тушаалыг нь нэг зэрэглэлээр бууруулж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргаанаас тухайн багшид нэг жилийн хугацаатай даалгавар өгч, дараагийн хичээлийн жилийн үнэлгээнд дахин орох боломж олгоно. Энэ үндэслэлээр зэрэглэл буурсан багшийн хувьд дараагийн үнэлгээний үр дүнгээр өмнөх зэрэглэлдээ дэвшин ажиллах эрх нь хадгалагдана. Дахин үнэлгээнд орохоос татгалзвал хөдөлмөрийн гэрээг цуцална.

14.3.5.(60-аас доош): Ажлын гүйцэтгэл нь зохих минимум шаардлагын түвшинд хүрээгүй, маш хангалтгүй ажилласан гэж үзнэ. Ийм үнэлгээ авсан багшийн хөдөлмөрийн гэрээг цуцална.

14.3.6. Үнэлгээний тайланд заасан буюу шаардсан бичиг баримтыг өөрөө бүрдүүлж өгөөгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр үнэлгээнд хугацаандаа ороогүй, орохоос зайлсхийсэн багшийг D үнэлгээ авсантай адилтган үзэж албан тушаалын зэрэглэлийг нь бууруулна.

14.4.Багшийн ажлын өөрийн үнэлгээний тайланг бичих заавар

Багшийн ажлын нэгдсэн үнэлгээнд орж буй багш энэ зааврыг баримтлан тайлан бичиж, багшийн үндсэн 3 төрлийн ажилд холбогдох зохих нотлох баримтуудыг бүрдүүлж, (зарим онцлог зүйлийг ялган тэмдэглэнэ) хавсаргасан байна. Мөн цаашдын зорилт, төлөвлөсөн ажлаа бичиж, нэгдсэн үнэлгээнд ороогүй онцлог ажил, ажлынхаа дуусгасан болон явцын, төлөвлөсөн үр дүнг тусгасан тайлбар нэмж болно.

Багшаас энд дурдсан ажлуудыг бүгдийг хийсэн байхыг шаардаж болохгүй.

Овог нэр: _____

Бүрэлдэхүүн сургууль: _____

Тэнхим: _____

Албан тушаал: _____

Тухайн албан тушаалд ажилласан жил: _____

Тайлангийн үндсэн хэсэгт багшийн ажлыг үнэлэх чиглэлүүдийн дагуу

- Сургалт, заах арга зүй,
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил,
- Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэсэн ажил гэсэн дэд хэсэг бүрээр гүйцэтгэсэн ажлаа тодорхой бичнэ.

Төгсгөлд нь боловсрол, мэргэжил дээшлүүлсэн болон гадаад хэл эзэмшсэн байдал, ажлын туршлага зэргийг багтаасан товч намтар (CV), бүтээлийн жагсаалт, ажлын төлөвлөгөө, зорилгоо тодорхойлон бичиж хавсарган, гарын үсгээ зурна.

14.5.Багшийн ажлыг үнэлэх үндсэн чиглэлүүд:

14.5.1.Сургалт, заах арга зүй

14.5.1.1.Сургалтын ажил (30%)

- ✓ Хичээлийн хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэстэй, боловсролын хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулах, хөгжүүлэх;

- ✓ Хичээлийн агуулгыг өмнөх болон залгамж хичээлтэй уялдуулж шинжлэх ухааны үндэстэй боловсруулах;
- ✓ Сургалтын хөтөлбөрийн болон хичээлийн үнэлгээг сургалтын чанарыг сайжруулахад тасралтгүй хэрэглэх;
- ✓ Холбогдох дүрэм журмын дагуу суралцагчийг үнэлэх үнэлгээний зарчмыг боловсруулж, үр дүнг цаашдын сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх;
- ✓ Хичээлийн үнэлгээний даалгаварт залан шинжилгээ хийж, сургалтын агуулга, арга зүйг сайжруулахад хэрэглэх;
- ✓ Хичээлийн агуулга, зорилгод тохируулан суралцагчийн мэдлэг, чадварыг олон төрлийн арга, хэлбэрээр үнэлэх, баяжуулах;
- ✓ Суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн (интернэт, мэдээллийн технологи, дуурайх (симуляци), асуудал шийдвэрлэх, тоглоомын арга, тодорхой тохиолдлын судалгаа (кейс) г.м) сургалтын шинэлэг аргыг нэвтрүүлэх

14.5.1.2.Сургалтын технологи ба хэрэглэгдэхүүн (30%)

- ✓ Суралцагчийн сэтгэл ханамжийн асуулгын үр дүнд үндэслэн өөрийн заах арга зүй, ур чадвараа үнэлэх, бие даан хөгжүүлэх;
- ✓ Хичээлийн суралцахуйн үр дүн, сургалтын нөхцөл байдалд тохируулан сургалтын олон талт хэрэглэгдэхүүнийг сонгох, хэрэглэх;
- ✓ Суралцагчийн бие даан болон багаар суралцахуйг дэмжсэн, сургалтын Онцлог, нөхцөл байдлаас хамааруулан сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгох; Бүтээлчээр хэрэглэх, судалгааны үр дүнг сургалтын хэрэглэгдэхүүн болгон хэрэглэх;
- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүн (лекц, семинар, лаборатори, дадлага гэх мэт)-ийг сургалтын цахим системд байршуулж, суралцагчдад нээлттэй хэрэглэх боломжийг бүрдүүлэх;
- ✓ Хичээл, сургалтад мэдээлэл харилцаа, технологийн дэвшилтэт арга, техник хэрэгсэл ашиглах;

- ✓ Сургалтын е-контент боловсруулах;

14.5.1.3.Суралцагчтай ажилласан байдал (30%)

- ✓ Хичээлийн бус цагт тодорхой хуваариар суралцагчдад сургалтын талаар зөвлөгөө өгөх, бие даан суралцах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- ✓ Суралцагчдад судалгааны ажилд үүсэж буй асуудлын шийдлийг олж харах, сорилтыг даван туулахад туслах;
- ✓ Клуб, дугуйлан удирдан хичээллүүлэх;
- ✓ Сургалтад интерактив орчин бүрдүүлэх, урамшуулах, сэдэлжүүлэх замаар багш, суралцагчдын суралцахуйг дэмжих;
- ✓ Суралцагчдын суурь мэдлэг, оюун ухаан, хүсэл сонирхол, сурах арга барил, хувь хүний хөгжлийн шат харилцан адилгүй байдлыг сургалтын явцад тусгах;

14.5.1.4.Даалгаварт болон бусад ажил (10%)

- ✓ Бакалаврын оюутны судалгааны ажил болон магистрантын дипломын ажилд шүүмж өгөх, шалгалт авах комисст ажиллах;
- ✓ Сургалтын арга технологийг боловсронгуй болгох, шинэчлэхтэй холбоотой тусгайлсан даалгавар гүйцэтгэх;
- ✓ Элсэлт, төгсөлтийн ажил зохион байгуулахад оролцох;
- ✓ Заах арга зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх;

14.5.2. Эрдэм шинжилгээний ажил

14.5.2.1.Эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл (60%)

- ✓ Дотоодын болон гадаадын мэргэжлийн индекс бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх;
- ✓ Сургуулийн, үндэсний болон олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлэх;
- ✓ Докторын зэрэг горилсон бүтээл туурвих;

- ✓ Шинжлэх ухааны онолын болон судалгааны баг, их семинарт судалгааны үр дүнгээ тогтмол хэлэлцүүлэх;
- ✓ Зохиогчийн эрхээр баталгаажуулсан бүтээл (ном, сурах бичиг) туурвих;
14.5.2.2.Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил, оюуны өмчийн бүтээл (20%)
- ✓ Шинэ бүтээл, оновчтой санал гаргаж, эрхийн хамгаалалт хийлгэх, патент, стандарт. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах. Зохиогчийн эрх авах үйлдвэрлэлд технологи нэвтрүүлэх;
- ✓ Эрдэм шинжилгээний төсөл, захиалгат болон гэрээт ажил; инновацийн төсөлд туслах болон үндсэн судлаачаар оролцох;
14.5.2.3.Эрдэм шинжилгээний бусад ажил (20%)
- ✓ Оюутан, магистрантын эрдэм шинжилгээний ажлыг удирдах, судалгааны арга зүйн зөвлөмж өгөх;
- ✓ Үндэсний нийгэмлэг, хороо, зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох;
- ✓ Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлийн хянан магадлагчаар ажиллах;
- ✓ гадаадын сургууль, байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- ✓ эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээр сургуульд мөнгөн болон материаллаг хөрөнгө оруулалт хийх;
- 14.5.3.Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ
14.5.3.1.Мэргэжлийн үйлчилгээ (50%)
- ✓ Эрдэм шинжилгээний хялбаршуулсан болон сурталчилгааны өгүүлэл Хэвлүүлэх;
- ✓ Сургалтын үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ, санал өгөх;
- ✓ Эрдэм шинжилгээний лаборатори, кабинет, тоног төхөөрөмж, мэдээллийн сан хариуцан ажиллах;
- ✓ Сургалт хариуцсан нэгж, тэнхимийн эрхлэгчийн даалгавраар багшийн хичээлд сууж, дагалдан суралцах;
- ✓ Сургуулийн захиргааны шийдвэрээр заавар, дүрэм, журам, бусад баримт бичиг боловсруулах, хяналт шалгалтад оролцох, оюутны байгууллагын үйл ажиллагаанд туслах;
- ✓ Улсын болон сургууль, тэнхимийн хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах комисст ажиллах;
- ✓ Мэргэжлийн холбоод, комисс, зөвлөлд томилолтын болон сонгуульт албан тушаал гүйцэтгэх;
- ✓ Зөвлөх багшаар ажиллах. Оюутны соёл, олон нийтийн ажил зохион байгуулах зэргээр суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажилд оролцох;
- ✓ Олон улсын болон улсын хэмжээний хурал, уулзалт семинар зохион байгуулах;
- ✓ Төр, засгийн бодлого, шийдвэрийн төсөлд шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар бодлогын баримт бичиг, илтгэл, төсөл боловсруулах;
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- ✓ Мэргэжлийн болон спорт, урлагийн хамтлаг удирдах, уралдаан тэмцээнд оролцох;
- 14.5.3.2.Нийгмийн үйлчилгээ (50%)
- ✓ Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр сурталчилгаа хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- ✓ Өдөр тутмын сонин, хэвлэлд өгүүлэл, нийтлэл хэвлүүлэх;
- ✓ ОУУБИС-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийн дагуу төрөл бүрийн сургалт явуулахад оролцох, зохион байгуулах;
- ✓ Нийгэм, ард иргэдийн дунд сургуулийн нэр хүндийг өргөхөд хувь нэмэр оруулахуйц бусад ажил гүйцэтгэх;
- ✓ Сургуульд тодорхой хэмжээний орлого оруулах ажил гүйцэтгэх;

- ✓ Байгууллага, иргэдэд боловсрол, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, эрдэм, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах;
- ✓ ЕБС-ийн сурагчдын авьяасыг нээн илрүүлж, дэмжих;

Арван тав. Гадаадын мэргэжилтэн, багшийг урьж ажиллуулах

Олон улсын байгууллага, Засгийн газрын хэлэлцээр, гадаадын их, дээд сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, төслийн дагуу гадаадын их, дээд сургуулиудаас гадаад багш, захиргааны мэргэжилтэн, судлаачийг тус сургуульд урьж ажиллуулж болно.

15.1.ОУУБИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимүүд шаардлагатай мэргэжилтэн, багш урих саналаа тус сургуулийн гадаад харилцааны албанд ирүүлнэ. Саналыг үндэслэн гадаадын мэргэжилтэн, багш урьж ажиллуулах асуудлыг МУ-ын хуулийн хүрээнд, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах журмын дагуу зохион байгуулна.

15.2.Гадаадын мэргэжилтэн, багшийг урьж ажиллуулах хүсэлт гаргах

15.2.1.Гадаадын мэргэжилтэн, багшийг урьж ажиллуулах зөвшөөрлийн хүсэлтийг сургуулийн гадаад харилцааны албанаас БСШУЯ-нд хүсэлт гаргаж холбогдох материалыг бүрдүүлж өгнө.

15.2.2. Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Гадаадын мэргэжилтэн, багш авч ажиллуулах зайлшгүй шаардлага хэрэгцээ, гүйцэтгэх ажил, үйлчилгээний хэмжээ, ажлын онцлог, мэргэжлийн ур чадварын талаар дэлгэрэнгүй тодорхойлсон албан бичиг
- Гадаадын мэргэжилтэн, багшийн дэлгэрэнгүй анкет
- Гадаадын мэргэжилтэн, багшийн диплом, сертификатын баталгаажуулсан хуулбар
- Паспортын хуулбар
- Гадаадын мэргэжилтэн, багштай байгуулсан хөдөлмөрийн гэрээ
- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Тухайн орны баталсан стандартын дагуу багшлах эрхийн сертификат эсвэл сурган, заах арга зүй эзэмшсэн сертификат, гэрчилгээ, дипломын хуулбар /Монгол хэлээр хөрвүүлж албан ёсоор баталгаажуулсан байна./
- Өмнө нь Монгол улсад ажиллаж байсан бол тухайн мэргэжилтэн багшийн талаарх байгууллагын тодорхойлолт
- Биений эрүүл мэндийг тодорхойлсон болон сүүлийн 3 сарын дотор ДОХ-ын шинжилгээ хийлгэсэн тухай шинжилгээний бичиг
- Бусад шаардлагатай бичиг баримт

15.2.3.Уригдаж буй гадаадын мэргэжилтэн, багшийн талаарх хүсэлтийг БШУЯ хүлээн авч танилцсаны үндсэн дээр зөвшөөрлийн бичиг олгоно.

15.2.4.БШУЯ-аас зөвшөөрсөн тухай хариуг авсан нөхцөлд ОУУБИС-ийн гадаад харилцааны албаны мэргэжилтэн албан бичиг /урилга/ үйлдэн харьяа дүүргийн хөдөлмөрийн хэлтсийн санал, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвөөс виз олгохыг зөвшөөрсөн албан бичиг авч, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт өгөн визээ авна.

15.3.ОУУБИС-д гадаад орноос уригдан ажиллах мэргэжилтэн, багшид тавигдах шаардлага

15.3.1. Гадаад орноос тус сургуульд уригдан ажиллах мэргэжилтэн, багш нар дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

- Багшаар ирж буй гадаадын мэргэжилтэн нь магистр буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх
- Үндсэн мэргэжлээрээ магистрын зэрэг хамгаалсан байх
- Мэргэжлийн дагуу тодорхой хугацаанд ажилласан байх
- Монгол Улсын хууль болон тухайн сургуулийн дотоод дүрэм журам, шаардлагыг мөрдлөг болгон ажиллах
- Нийгмийн ямар нэгэн халдварт өвчингүй байх

15.3.2. Гэр бүлийн хамт ирэх тохиолдолд дараах материалыг бүрдүүлсэн байна.

- Гэрлэлтийн баталгаа, эсвэл гэрлэсэн нь үнэн болохыг тодорхойлсон албан бичиг
- Гэр бүлийн гишүүдийн гадаад паспортын хуулбар, цээж зураг гэх мэт бичиг баримтыг бүрдүүлж авчирна.

15.4. Албан тушаалын зэрэглэл

15.4.1. Гадаад багшийн албан тушаалын зэрэглэлийг тус сургуулийн багшийн асуудал эрхэлсэн хүний нөөцийн зөвлөл, холбогдох журмын дагуу тогтооно.

15.4.2. Хүний нөөцийн зөвлөлөөс тогтоосон зэрэглэлийн дагуу гадаад багшийн ажиллах цагийн ачааллыг сургуулийн ректорын тушаалаар батална.

15.5. Ажиллуулах хугацаа болон гүйцэтгэх цаг

Гадаад багш нь монголын хөдөлмөрийн хуульд заасан тэтгэврийн наснаас үл хамааран ректорын тушаалаар мөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн хөдөлмөрийн гэрээг сунгах мөн дуусгавар болгож болно.

15.5.1. Гэрээ сунган ажиллуулах шалгуур

- Гадаад багшийн сургалт, эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний ажлын үр дүн
- Тухайн гадаад багшийн харьяалах салбар, тэнхим нь гэрээ сунгаж ажиллуулах хүсэлтэй бол багшийн талаарх үнэлгээ дүгнэлт
- Гадаад багшийн гэрээг сунгахдаа дээрх 2 заалтын үнэлгээ дүгнэлтийг үндэслэн ректор шийдвэрлэнэ.
- Гадаад багшийн гэрээг сунгаж ажиллуулаагүй тохиолдолд гэрээг шууд дуусгавар болгоно.
- Багшийн хувьд захиргааны албанд голлон үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд ректорын шийдвэрийг харгалзан үзнэ.

15.5.2. Гэрээг цуцлах

Дор дурдсан тохиолдолд гэрээний хугацаанаас үл хамааран гэрээг цуцална.

Хариуцаж авсан үүрэгт ажилдаа хайнга хандах, ажил гүйцэтгэх чадвар дутуу гэж салбар болон тэнхимийн эрхлэгч нар дүгнэж хүний нөөцийн зөвлөлийн хурлаар орон ректорын шийдвэр гарсан тохиолдолд

- Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон
- Ажиллах гэрээний нөхцөлийг зөрчсөн
- Анкет үнэн зөв бөглөөгүй, ямар нэгэн хуурамч бичиг баримт бүрдүүлсэн буюу ашигласан
- Багшийн ёс зүйн дүрэм, журмыг зөрчсөн
- Энэ журамд заагаагүй нөхцөлд тус сургуулийн хүний нөөцийн зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэнэ.

15.5.3. Гүйцэтгэх үүрэг

15.5.3.1. Гадаад багшийн хувьд Профессор багшийн журмын 9.3 дахь заалтын дагуу нийт гүйцэтгэлийн ажлыг тооцно. Эрдэм шинжилгээний кредит цагт төрөлх хэлээрээ хэвлэсэн бүтээлийг нь тооцож болно.

15.5.3.2. Цалин хөлс, бусад зүйл

Гадаад багшийн цалин хөлсийг хөдөлмөрийн гэрээнд тусгасан тухайн багшийн албан тушаал, албан тушаалын зэрэглэл, ажлын байрны тодорхойлолт, ажлын ачааллын хэмжээ зэргийг харгалзан ректор тогтооно. Гадаад багштай холбоотой бусад асуудлыг ректор тусгайлан шийдвэрлэнэ.

15.5.4. Хүлээх үүрэг, хариуцлага

Тус сургуульд ажиллахаар болсон гадаад багш нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Гадаад багш нь тус сургуулийн багшийн ажлын холбогдох журмын дагуу ажил үүрэг гүйцэтгэнэ.

15.5.4.1. Гэрээнд заасан хичээлийн цагийг баримтална.

15.5.4.2. Илүү цагийн мөнгийг тус сургуулийн үндсэн багштай адил тооцож олгоно. Түүнчлэн хариуцсан хичээлээ заагаагүй, цагаа гүйцээгээгүй тохиолдолд тухайн жилийн дутуу заасан цагийн тооцоог цалингаас суутгаж болно.

15.5.4.3. Тэнхимийн хүсэлтийг үндэслэн ОУУБИС-ийн зөвлөх багшийн ажиллах журмын дагуу оюутнуудыг удирдаж, зөвлөж ажиллана.

15.5.4.4. Тус сургуулиас гадна өөр байгууллагад ажиллахыг зөвшөөрөхгүй бөгөөд энэ заалт нь монгол улсын холбогдох хуулийн хүрээнд зохицуулагдана.

15.5.4.5. Улирлын дундуур хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, сургуулийн удирдлага, гадаад харилцааны албанд мэдэгдэлгүй гадаад, дотоодод явахыг

15.5.5. ОУУБИС-ийн хүлээх үүрэг, хариуцлага

15.5.5.1. Гадаадын мэргэжилтэн, багшид сургуулийн дотоод дүрэм, журам тухайн ажил үүрэгтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомжийг танилцуулна.

15.5.5.2. Гадаадын мэргэжилтэн, багшид сургуулийн талаарх мэдээлэл, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, амралт, баярын өдрүүд болон урлаг спорт зэрэг олон нийтийн арга хэмжээг мэдээлж, тэдгээрт оролцох бололцоогоор хангана.

15.5.5.3. Уригдаж буй гадаадын иргэний эрүүл мэндийн даатгал, ажил дээрх гэнэтийн ослын даатгалын тухай асуудлыг Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар зохицуулна.

15.5.5.4. Гадаад профессор багшийн монгол дахь визтэй холбогдох асуудлыг хариуцсан алба, хэлтэс хариуцах бөгөөд гарсан эхний зардлаас бусад зардлыг хувь хүн бүрэн хариуцна.

15.5.5.5. Монголд анх удаа ирж буй гадаад профессор багшийг нисэх онгоцны буудлаас авах ба монголд амьдрах хугацаанд аюулгүй байдал бусад зүйлээр туслах /амьдрах орон байр, утас телефон гэх мэт/

15.5.5.6. Монголд анх удаа ирж байгаа гадаад багшийн хувьд монгол хэлний сургалтад хамрагдах тал дээр сургуулиас зуучилж болно.